Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2020 оны 100 тоот тушаалын
7 дугаар хавсралт

# ХАН-УУЛ ДҮҮРГИЙН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН 2025 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

| Д/д | Бодлогын баримт бичиг, хууль тогтоомж | Төсөв | Шалгуур үзүүлэлт | Суурь түвшин | Зорилтот түвшин | Хүрсэн түвшин буюу хэрэгжилт(хүрээгүй бол тайлбар) | Хувь |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
| **ДЗДҮАХ-ийн зорилго1.1. Нийгмийн дэд бүтцийн хүртээмжийг зохистой түвшинд хүргэх бодлого төлөвлөлтийг хэрэгжүүлж, иргэд оршин суух буй газраасаа 20 минутын зайд нийгмийн суурь үйлчилгээ авах боломжийг үе шаттайгаар бүрдүүлнэ.** | | | | | | | |
| **Зорилт 1**. Орон нутгийн зэрэглэлтэй "Хан-Уул", "Яармаг", "Буянт-Ухаа" хотууд шинээр байгуулах зохион байгуулалтын бэлтгэл ажлыг талуудын оролцоотойгоор хангана.(НЗДҮАХ 1.2.1, ДЗДҮАХ 1.1.1) | | | | | | | |
| 1. | Арга хэмжээ:1.1 Орон нутгийн зэрэглэлтэй "Хан-Уул", "Яармаг", "Буянт-Ухаа" хотууд шинээр байгуулахад шаардагдах суурь судалгаа, мэдээллийг боловсруулж холбогдох дээд шатны | - | Суурь судалгаа, мэдээллийг боловсруулсан эсэх | - | Суурь судалгаа, мэдээллийг тухай бүр боловсруулж, дээд шатны байгууллагад хүргүүлнэ. | Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийг шинэчлэн баталсантай холбогдуулан Монгол улсын Их хурлын 2024 оны 72 дугаар тогтоолоор Улаанбаатар хотыг 2026 оны 06 дугаар сарын 01-ний өдрөөс 14 орон нутгийн зэрэглэлтэй хот болгохоор шийдвэрлэсэн. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | байгууллагад уламжилна. | | | | | Тус тогтоолын хэрэгжих хугацааг Улсын Их Хурлын 2025 оны 46 дугаар тогтоолоор 2027 оны 01 дүгээр сарын 01-ний өдрөөс дагаж мөрдөхөөр өөрчлөлт оруулсан.<br><br>Хан-Уул дүүргийн хувьд Буянт-Ухаа хот, Хан-Уул хот, Яармаг хот болон хуваагдахаар төлөвлөсөн. 20 минутын хот үндсэний хороонд шинээр байгуулагдах хот болон нэгжүүдийн бүтэц, чиг үүргийн хуваарилалтын судалгаа, танилцуулгыг боловсруулж, "Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулгын хэрэгжилтийн бэлтгэл ажил, 20 минутын хот стандартыг хангуулах" чиг үүргийн хүрээнд Хууль, эрх зүйн хэлтэс, бүтэц, орон тооны судалгааг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс, зардлын тооцооллын судалгааг Санхүү, төрийн сангийн хэлтэс, Санхүүгийн тасагтай хамтран тус тус гаргаж, мэдээллийг загвар хүснэгтийн дагуу нэгтгэн Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнд заасан хугацаанд хүргүүлсэн. | |
| **Зорилт 2.** Хороодыг нэгтгэн зохион байгуулж 120 мянгат, Зайсан, Зэрмэл, Яармаг, Арцат, Буянт-Ухаа орчмыг хорооллын зохион байгуулалтад шилжүүлэх бэлтгэл хангана. (ДЗДҮАХ 1.1.2) | | | | | | | |
| 2. | Арга хэмжээ: 2.1 Хороодыг нэгтгэн хорооллын зохион байгуулалтад шилжүүлэхэд | - | Суурь судалгаа, мэдээллийг боловсруулсан эсэх | - | Суурь судалгаа, мэдээллийг тухай бүр боловсруулж, дээд шатны | "Хот тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн шинэчилсэн найруулга"-ын бэлтгэл ажлын хүрээнд судалгаа, мэдээллийг дараах 3 чиглэлээр гаргаж нэгтгэн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шаардагдах суурь судалгаа, мэдээллийг боловсруулж холбогдох дээд шатны байгууллагад уламжилна. | | | | байгууллагад хүргүүлнэ. | Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнд хүргүүлсэн. Үүнд;<br><br>*Чиг үүргийн шинжилгээгээр* Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж түүний удирдлагын тухай хуулиар одоо мөрдөгдөж байгаа нийслэлийн нийт 49 чиг үүргээс шинээр байгуулагдах хотод 37, хороололд 30, Монгол Улсын нийслэл Улаанбаатар хотын эрх зүйн байдлын тухай хуулийн одоо мөрдөгдөж байгаа нийслэлийн нийт 22 чиг үүргээс шинээр байгуулагдах хотод 10, хороололд 21, Хот, тосгоны эрх зүйн байдлын тухай хуулийн одоо мөрдөгдөж байгаа нийслэлийн нийт 30 чиг үүргээс шинээр байгуулагдах хотод 30 чиг үүрэг тус тус шилжих боломжтой.<br><br>*Бүтэц, орон тооны судалгаагаар* одоогийн батлагдсан Засаг даргын Тамгын газрын 100, хорооны 100 болон 270 хэсгийн ахлагч, нийт 470 орон тоог 3 хот, 8 хороололд дараах байдлаар хуваарилан байршуулсан. Үүнд;<br>-Хан-Уул хотод удирдлага 3, 7 хэлтэст 47, нийт 50 албан хаагчтай, 4 нэгж хороолол тус бүрд удирдлага 3, 3 хэлтэс, 1 тасаг 35-36, нийт 154 буюу 204 албан хаагч;<br>-Яармаг хотод удирдлага 3, 7 хэлтэст 45, нийт 48 албан | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хаагчтай, 2 нэгж хороолол тус бүрд удирдлага 3, 3 хэлтэс, 1 тасаг 35-36, нийт 77 буюу 125 албан хаагч;<br>-Буянт-Ухаа хотод удирдлага 3, 7 хэлтэст 45, нийт 48 албан хаагчтай, 2 нэгж хороолол тус бүрд удирдлага 3, 3 хэлтэс, 1 тасаг 35-36, нийт 77 буюу 125 албан хаагч;<br>Нийт 3 хот, 8 хороолold 454, зайлшгүй нэмэгдэх шаардлагатай 26; нийт 470 төрийн албан хаагч, хэмнэгдсэн орон тоо нь Баянгол дүүргээс Хан-Уул хотод шилжин ирэх хорооны албан хаагчийн орон тоо.<br>*<u>Зардлын тооцооллын судалгаагаар</u>* 9 төрлийн тавилга 1278, 5 төрлийн тоног төхөөрөмж 472, нийт 1750 ширхэг тавилга, тоног төхөөрөмжөөр 470 төрийн албан хаагчийг хангах боломжтой. | |
| **Зорилт 3.** Анхан шатны нэгжид чиг үүргийг шилжүүлэх замаар иргэдээс нийтлэг гардаг санал, хүсэлт, гомдлыг шууд бие даан шуурхай шийдвэрлэх зохион байгуулалтад шилжинэ. (ДЗДҮАХ 1.1.4) | | | | | | | |
| 3. | Арга хэмжээ:3.1<br>Иргэдийн өргөдөл, гомдол, хүсэлтийг ERP "Өргөдөл гомдлын нэгдсэн систем" болон бусад арга хэрэгслээр хүлээн авч, шийдвэрлэлтийн хариуг иргэнд шуурхай өгч ажиллана. | - | Шийдвэрлэлтийн дундаж хугацаа | 08 хоног, 09 цаг, 36 минут. | 08 хоног, 09 цаг, 36 минут. | Дүүргийн хэмжээнд 2025 оны жилийн эцсийн байдлаар 5650 өргөдөл, гомдол ирснээс хугацаандаа шийдвэрлэсэн 5554, судлагдаж байгаа 94, хугацаа хэтрүүлэн шийдвэрлэсэн 1 өргөдөл, гомдол байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 06 хоног 01 цаг 36 минут. Засаг даргын Тамгын газарт 995 өргөдөл, гомдол ирснээс хугацаандаа шийдвэрлэсэн 973, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | судлагдаж байгаа 22 өргөдөл, гомдол байна. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа 06 хоног 05 цаг 33 минут. Нийслэлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаа 08 хоног 06 цаг 28 минут. Шийдвэрлэлтийн индексээр 0,872 буюу А, нийслэлийн шийдвэрлэлтийн индекс 0,850 буюу А үзүүлэлтээс өндөр байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад өргөдөл, гомдлын тоо дүүргийн хэмжээнд 19,4%-иар, Засаг даргын Тамгын газрын хэмжээнд 5,9%-иар тус тус буурсан. Шийдвэрлэлтийн дундаж хугацаа дүүрэг 11 цаг 02 минутаар, Засаг даргын Тамгын газар 02 хоног 04 цаг 03 минутаар, зөрчлийн тоо 39,7%-аар буурсан байна. Нийслэлийн шийдвэрлэлтийн дундаж хугацаанаас 02 хоног 16 цаг 27 минутаар багассан үзүүлэлттэй байна.<br>Өргөдөл, гомдлын шийдвэрлэлтийг эрчимжүүлэх чиглэлээр Засаг даргын дэргэдэх, хэлтэс албад, 25 хорооны өргөдөл, гомдол хариуцсан албан хаагчдад 2 удаагийн сургалт зохион байгуулж, өдөр тутамд арга зүйн зөвлөгөө мэдээллийг өгсөн. Мөн өргөдөл, гомдлын мэдээг нэгтгэн зөрчил гаргасан албан хаагчаас тухай бүр хариу тайлбарыг авч Засаг даргын Тамгын газрын даргын албан бичгээр нийт 22 удаа Нийслэлийн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | үйлчилгээний нэгдсэн төвд хүргэж ажилласан. | |
| 4. | Арга хэмжээ:3.2 Дүүргийн Засаг даргын иргэдтэй хийх уулзалтыг зохион байгуулна. | - | Хэрэгжилтийн хувь | 2024 онд 11 уулзалт зохион байгуулж, 128 иргэний санал хүсэлтийг шийдвэрлэсэн. | 100 | Хан-Уул дүүргийн иргэдэд нэг удаагийн буцалтгүй тусламж үзүүлэх тухай журмын дагуу иргэнээс ирсэн хүсэлтийг хүлээн авч, журмын шаардлага хангасан 89 иргэнд дүүргийн Засаг даргын захирамжаар 55,935,000 (Тавин таван сая есөн зуун гучин таван мянган), төгрөгийн буцалтгүй тусламж олгох ажлыг зохион байгуулсан. | 100 |
| **Зорилт 4.** Өрхийн эмнэлгүүдийн зарим зохион байгуулалтуудыг нэгтгэж хороолол бүрд **"Эрүүл мэндийн төв"** байгуулах ажлыг талуудтай хамтран үе шаттай зохион байгуулна. (НЗДҮАХ 2.1.5, ДЗДҮАХ 1.1.5) | | | | | | | |
| 5. | Арга хэмжээ:4.1 Дүүргийн 10 дугаар хороо, Нисэхийн бүсэд өрхийн эрүүл мэндийн төвийн барилгыг барьж ашиглалтад оруулна. | 910.4 (ДТХО) | Ажлын явц, хувь | 50% /2024 он/ | 100 | Дүүргийн төсвийн хөрөнгөөр 2024-2025 онд дамжин хэрэгжиж буй өрхийн эрүүл мэндийн төвийн барилга угсралтын ажлыг Элбэг гүн ХХК гүйцэтгэж, 2025 оны 10 дугаар сарын 24-ний өдөр барилга байгууламжийг байнгын ашиглалтад оруулах комисс ажиллуулах хүсэлт өгсөн. Улсын комисс ажиллах шатанд хэрэгжиж байна | 100 |
| **Зорилт 5.** Төрийн цахим үйлчилгээний **"Хурдан цэг"**-үүдийг иргэдэд ойрхон хүртээмжтэй байх зохион байгуулалт хийж ажиллуулна. (ДЗДҮАХ 1.1.6) | | | | | | | |
| 6. | Арга хэмжээ:5.1 Иргэд төрийн үйлчилгээний "Хурдан" цэгээс үйлчилгээ авах нөхцөлийг сайжруулна. | - | "Хурдан" цэгийн үйлчилгээ авах нөхцөлийг сайжруулсан хорооны тоо | 25 хороонд "Хурдан" цэгүүд нээгдсэн. | 25 хорооны "Гэрэгэ киоск" төхөөрөмжийн хэвийн үйл ажиллагааг хангасан байна. | Дүүргийн 25 хорооны байранд байршуулсан "Хурдан" цэгийн хэвийн үйл ажиллагааг хангах ажлын хүрээнд шинээр томилогдсон болон шилжин ажилласан Зохион байгуулагч нарт тоон гарын үсэг нээлгэж, системд нэвтрэх эрх олгох ажлыг Төрийн цахим үйлчилгээний зохицуулалтын газартай хамтран тухай бүр зохион байгуулсан. "Гэрэгэ киоск" машины үйл | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | ажиллагааг сайжруулах хүрээнд 2, 5, 8, 10, 17, 18 дугаар хорооны “Гэрэгэ киоск” машиныг засварлуулах, 12 дугаар хорооны “Гэрэгэ киоск” машиныг 15 дугаар хорооны нэг цэгийн үйлчилгээний зааланд шилжүүлж хэвийн ажиллагааг хангах ажлыг “Гэрэгэ системс” ХХК-тай хамтран зохион байгуулсан. Ирэх онд дүүргийн 15, 16, 20 дугаар хороонд “Гэрэгэ киоск” машиныг шинэчлэхээр төсвийн саналыг хүргүүлсэн. | |
| **Зорилт 6.** Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгийн хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхэд багачууд оршин суугаа газраасаа **20** минутын зайд боловсролын үйлчилгээ авах боломжийг үе шаттайгаар бүрдүүлнэ. (ДЗДҮАХ 1.1.8) | | | | | | | |
| 7. | Арга хэмжээ: 6.1 Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлж, сургууль, цэцэрлэгийн барилгыг шинээр барих, өргөтгөх, засварлах ажлыг хэрэгжүүлнэ. | **17,606.9 (НТХО)** | Нэмэгдүүлсэн суудал, тоо | 7500 /2021-2024 он/ | 2240 | Хан-Уул дүүрэгт 2024-2025 онд гадаадын тусламж, улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 8560 суудалтай 12 сургууль баригдахаар төлөвлөгдсөнөөс 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 1920 суудалтай 3 сургуулийн барилга ашиглалтад орсон.<br>Төсөл, арга хэмжээг төсвийн эх үүсвэрээр нь авч үзвэл:<br>1.Гадаадын зээл тусламжаар 22 дугаар хороонд хэрэгжиж байгаа 1200 суудалтай сургуулийн барилгын ажил, гүйцэтгэл 60 хувь;<br>2.Нийслэлийн төсвийн хөрөнге оруулалтаар 4, 17, 18, 23 дугаар хороонд хэрэгжиж байгаа нийт 4000 суудалтай 5 сургуулийн барилгын ажил, гүйцэтгэл дунджаар 60 хувь; | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 3. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 3, 14, 16 дугаар хороонд хэрэгжих нийт 1440 суудалтай 2 сургуулийн барилгын ажлын зураг төсөв батлагдсан, 1 барилгын ажил гүйцэтгэгч шалгаруулах шатанд байна. | |
| | | | Ашиглалтад орсон сургууль, тоо | 12 /2021-2024 он/ | 3 | Хан-Уул дүүрэгт 2025 онд улсын төсвийн хөрөнгөөр дүүргийн 2 дугаар хороонд 640 суудалтай 15 дугаар сургуулийн өргөтгөл, 8 дугаар хороонд 640 суудалтай сургуулийн барилга, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 16 дугаар хороонд 640 суудалтай сургуулийн барилга ашиглалтад орсноор сургуулийн хүчин чадлыг 1920 суудлаар нэмэгдүүлсэн. | |
| | | 200.0 (НОНХС) | Засварласан сургуулийн барилга, тоо | 2 /2024 он/ | 1 | Дүүргийн 34, 41, 60 дугаар сургуулийг бохир усны шугамд холбох ажлын зураг, төсвийг "ДНТ" ХХК гүйцэтгэж, зураг, төсвийг магадлалаар батлуулсан бөгөөд худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна.<br>Нийслэлийн төсвийн 1,194.0 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжих 53, 165, 250, 35 дугаар цэцэрлэг, 18, 59, 156, 89 дүгээр сургуулийн дээвэр засварын ажлын гүйцэтгэгчээр "Очир-шүр" ХХК шалгарсан бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар гэрээ байгуулагдаагүй, 2026 онд хэрэгжинэ.<br>Нийслэлийн төсвийн 1,445.9 сая төгрөгийн хөрөнгөөр 65, 209, 190, | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 218, 41 дүгээр цэцэрлэгийн шугамын засвар, 60 дугаар сургуулийн спорт заал, 26 дугаар сургуулийн урлаг заалны засвар, 114 дүгээр сургуулийн цэвэр, бохир усны шугамын засварын ажлыг "Очир шүр" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 209, 190 дүгээр цэцэрлэгийн шугам засвар, 60 дугаар сургуулийн спорт заалны засвар, Эрүүл мэндийн төв В1 давхрын инженерийн хангамжийн шугам сүлжээний засварын ажлууд хэрэгжиж дууссан. | |
| | | **5,698.3 (УТХО)0 5,306.1 (НТХО)** | Ашиглалтад орсон бага сургууль, цэцэрлэгийн тоо | 2 /2023-2024 он/ | 6 | Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр Хан-Уул дүүргийн 8, 9, 12, 14, 16, 24 дүгээр хороонд 1260 суудал, 700 орны хүчин чадалтай 7 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажил хэрэгжиж байгаагаас<br>12, 14, 16, 24 дүгээр хороонд баригдсан 4 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга ашиглалтад орсон.<br>Он дамжин хэрэгжиж байгаа бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгыг санхүүжилтийн эх үүсвэр, явцаар нь авч үзвэл:<br>1.Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар 8 дугаар хороонд хэрэгжиж буй 180 суудал, 100 орны хүчин чадалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажил 40 хувийн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч "Хаш гоёо" ХХК<br>2.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 9 дүгээр хороонд хэрэгжиж буй 180 суудал, 100 орны хүчин чадалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч "Шунхлайн шандас" ХХК<br>3.Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 12 дугаар хороонд хэрэгжиж буй 180 суудал, 100 орны хүчин чадалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч "Жавхлант тур" ХХК | |
| | | | Ашиглалтад орсон суудал, орны тоо | 360; 200 /2021-2024 он/ | 1080; 600 | Боловсролын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд улс, нийслэлийн төсвийн хөрөнгөөр Хан-Уул дүүргийн 8, 9, 12, 14, 16, 24 дүгээр хороонд хэрэгжиж буй 1260 суудал, 700 орны хүчин чадалтай 7 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын төсөл арга хэмжээний хүрээнд 12, 14, 16, 24 дүгээр хороонд 4 бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилга ашиглалтад орсноор сургууль, цэцэрлэгийн хүчин чадлыг 720 суудал, 400 ороор нэмэгдүүлсэн.<br><br>Улсын төсвийн хөрөнгөөр 8 дугаар хороонд хэрэгжиж буй 180 суудал, 100 орны хүчин чадалтай бага сургууль, цэцэрлэгийн цогцолбор барилгын ажил 40 хувь, | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийслэлийн төсвийн хөрөнгөөр 9, 12 дугаар хороонд хэрэгжиж буй 360 суудал, 200 орны хүчин чадалтай 2 бага сургууль, цэцэрлэгийн барилын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. | |
| | | 10,183.3 (НТХО) 9,842.6 (ДТХО) | Нэмэгдүүлсэн ор, тоо | 2990 /2021-2024 он/ | 1830 | Хан-Уул дүүрэгт улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 1835 орны хүчин чадалтай 13 цэцэрлэг барилга ашиглалтад оруулахаар төлөвлөгдсөнөөс 2025 онд улсын төсвийн хөрөнгөөр 270 ортой 67, 71 дүгээр цэцэрлэгийн өргөтгөл, 1 дүгээр хороонд 240 ортой цэцэрлэгийн барилга, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 15, 23 дугаар хороонд нийт 445 ортой 4 цэцэрлэгийн барилга, дүүргийн төсвийн хөрөнгөөр 20 дугаар хороонд 100 ортой цэцэрлэгийн барилга тус тус ашиглалтад орж, цэцэрлэгийн хүртээмжийг 1055 орны багтаамжтай 8 барилгаар нэмэгдүүлсэн. | |
| | | | Ашиглалтад орсон цэцэрлэг, тоо | 22 /2021-2024 он/ | 12 | Хан-Уул дүүрэгт улс, нийслэл, дүүргийн төсвийн хөрөнгөөр нийт 1835 орны хүчин чадалтай 13 цэцэрлэг барилга ашиглалтад оруулахаар төлөвлөгдсөнөөс улсын төсвийн хөрөнгөөр 270 ортой 67, 71 дүгээр цэцэрлэгийн өргөтгөл, 1 дүгээр хороонд 240 ортой цэцэрлэгийн барилга, нийслэлийн төсвийн хөрөнгөөр 15, 23 дугаар хороонд нийт 445 ортой 4 цэцэрлэгийн барилга, дүүргийн төсвийн хөрөнгөөр 20 | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дугаар хороонд 100 ортой цэцэрлэгийн барилга тус тус ашиглалтад орсон.<br>Он дамжин хэрэгжиж буй цэцэрлэгийн барилгуудыг санхүүжилтийн эх үүсвэр, явцаар авч үзвэл:<br>1. Улсын төсвийн хөрөнгөөр 18 дугаар хороонд хэрэгжих 200 ортой цэцэрлэгийн барилга эдэлбэр газрын хэмжээ өөрчлөгдсөнтэй холбогдуулан зураг төсвийг өөрчилж, боловсруулж байна. Гүйцэтгэгч Юувоку ХХК<br>2. Нийслэлийн төсвийн хөрөнгөөр 8 дугаар хороонд хэрэгжиж буй 240 ортой цэцэрлэгийн барилгын ажил 90 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгчээр "Жинст цамхаг" ХХК<br>3. Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 9 дүгээр хороонд хэрэгжиж буй 100 ортой цэцэрлэгийн барилгын ажил 85 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. Гүйцэтгэгч "Инерци" ХХК, "Тавантод констракшн" ХХК<br>4.Дүүргийн төсвийн хөрөнгөөр 23 дугаар хороонд хэрэгжиж буй 240 ортой цэцэрлэгийн барилгын ажил зураг төсөл магадлал хийгдэх шатанд хэрэгжиж байна. Гүйцэтгэгч "Төгс баялаг алтай" ХХК | |
| | | **110.1 (ДОНХС)** | Засварласан цэцэрлэгийн барилга, тоо | - | 1 | Дүүргийн 34, 41, 60 дугаар сургуулийг бохир усны шугамд холбох ажлын зураг, төсвийг "ДНТ" ХХК гүйцэтгэж, зураг, төсвийг | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | магадлалаар батлуулсан бөгөөд худалдан авах ажиллагааны шатанд хэрэгжиж байна.<br><br>Нийслэлийн төсвийн 1,194.0 сая төгрөгийн хөрөнгөөр хэрэгжих 53, 165, 250, 35 дугаар цэцэрлэг, 18, 59, 156, 89 дүгээр сургуулийн дээвэр засварын ажлын гүйцэтгэгчээр "Очир шүр" ХХК шалгарсан бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 22-ны өдрийн байдлаар гэрээ байгуулагдаагүй, 2026 онд хэрэгжинэ.<br><br>Нийслэлийн төсвийн 1,445.9 сая төгрөгийн хөрөнгөөр 65, 209, 190, 218, 41 дүгээр цэцэрлэгийн шугамын засвар, 60 дугаар сургуулийн спорт заал, 26 дугаар сургуулийн урлаг заалны засвар, 114 дүгээр сургуулийн цэвэр, бохир усны шугамын засварын ажлыг "Очир шүр" ХХК гүйцэтгэж байгаа бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар 209, 190 дүгээр цэцэрлэгийн шугам засвар, 60 дугаар сургуулийн спорт заалны засварын ажлууд хэрэгжиж дууссан. | |
| *ДЗДҮАХ-ийн 1.1. зорилгын хүрээнд 6 зорилт 7 арга хэмжээ 98,5 хувьтай хэрэгжсэн.* | | | | | | | |
| **ДЗДҮАХ-ийн зорилго1.2.Төрийн үйлчилгээний чанар, хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | |
| **Зорилт 7.** Хүний нөөцийн бодлого чиглэлийн хүрээнд төрийн албан хаагчдын "Сургалт, ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр"-ийг хэрэгжүүлэх ажлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ 1.2.1) | | | | | | | |
| **8.** | Арга хэмжээ:7.1 Төрийн албан хаагчдын "Сургаж, мэргэшүүлэх 2025 оны | - | Хэрэгжилтийн хувь | Хөтөлбөрийн 2024 оны төлөвлөгөөний хэрэгжилт 95 | 90 | Хан-Уул дүүргийн Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 01 дүгээр сарын 31-ний өдрийн А/15 дугаар тушаалаар "Сургалт, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөө"-г батлуулж, хэрэгжилтийг хангана. | | | хувьтай зохион байгуулсан. | | ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах хөтөлбөр" болон тус хөтөлбөрийг хэрэгжүүлэх "Сургалт, хөгжлийн 2025 оны нэгдсэн төлөвлөгөө"-г батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан. Төлөвлөгөөнд 2 зорилтын хүрээнд 16 арга хэмжээ тусгагдсанаас, 14 арга хэмжээ бүрэн хэрэгжиж, 1 арга хэмжээ хэрэгжилт дутуу, 1 арга хэмжээ хэрэгжих боломжгүй, төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт 97.3 хувь хэрэгжсэн.<br><br>Төлөвлөгөөний хэрэгжилтийн хүрээнд:<br>-Удирдлагын академийн эрхэлсэн түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 1, ахлах түшмэлийн мэргэшүүлэх сургалтад 2, мэргэшүүлэх дунд хугацааны давтан сургалтад 4, дунд хугацааны багц сургалтад 2, шинэ томилогдсон төрийн албан хаагчийг чиглүүлэх 40 цагийн сургалтад 16, Стратеги төлөвлөгөө боловсруулах чадавхжуулах сургалтад 1, Худалдан авах ажиллагааны А3 сертификат олгох сургалтад 16, Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн арга зүйн сургалтад 15, Архив, албан хэрэг хөтлөлтийн гэрчилгээт сургалтад 3, өгөгдөл боловсруулах программын сургалтад 4, төрийн албан хаагчийг чадавхжуулах гадаа сургалтад 20, нийт 11 төрлийн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтаар 74 албан хаагчийг мэргэшил дээшлүүлсэн.<br>-Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын Хүний нөөцийн хөгжлийн төвийн богино хугацааны хуваарьт 40 удаагийн сургалтад 198, бусад байгууллагаас зохион байгуулсан богино хугацааны 20 удаагийн сургалтад давхардсан тоогоор 189, нийт 71 удаагийн сургалтад 461 албан хаагчийг тус тус хамруулсан. | |
| 9. | Арга хэмжээ:7.2<br>Албан хаагчдын нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх ажлыг холбогдох журмын дагуу тухай бүр зохион байгуулж, хэрэгжилтийг тайлагнана. | - | Хэрэгжилтийн хувь | 53 албан хаагчийн нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх ажлыг 100 хувь зохион байгуулсан. | 100 | Тайлант хугацаанд ажлын гүйцэтгэл, үр дүн, мэргэшил, тогтвор суурьшилтай ажилласан байдал, амьдралын нөхцөлийг харгалзан 38 албан хаагчийн нийгмийн баталгааг хангахад дэмжлэг үзүүлэх ажлыг 100% зохион байгуулсан бөгөөд дэмжлэг хамрагдсан төрийн захиргаа, төрийн тусгай болон үйлчилгээний 38 албан хаагчтай "Хариуцлагын гэрээ" байгуулсан.<br>Засаг даргын Тамгын газрын хөдөлмөрийн дотоод журмын дагуу 18 албан хаагчид нэг удаагийн буцалтгүй тусламж, 20 албан хаагчид урамшуулал олгох шийдвэрийг батлуулж, хэрэгжилтийг зохион байгуулсан. | 100 |
| **Зорилт 8.** Авлигатай тэмцэх үндэсний хөтөлбөр, Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх үндэсний хөтөлбөрийн биелэлтийг хангуулах, төрийн албан хаагчдыг авлигын эрсдэл, ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээг зохион байгуулна. (ДЗДҮАХ 1.2.2) | | | | | | | |
| 10. | Арга хэмжээ:8.1<br>Төрийн албан хаагчийн ёс зүйн | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Ёс зүйн дэд хорооны 2024 оны үйл ажиллагааны | 95 | Засаг даргын Тамгын газрын Ёс зүйн дэд хорооны 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг 2025 | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зөрчлийн шалтгаан, нөхцөлийг тогтоож, зөрчлийг бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр ёс зүйн дэд хорооны 2025 оны ажлын төлөвлөгөөг батлуулж, хэрэгжилтийг хангана. | | | төлөвлөгөөний хэрэгжилт 96 хувь | | оны 01 дүгээр сарын 31-ний өдөр батлуулж төлөвлөгөөнд Ёс зүйн зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр 7, ёс зүйн зөрчлийг хянан шийдвэрлэх чиглэлээр 3, дэд хорооны хэвийн үйл ажиллагааг хангах чиглэлээр 3, үйл ажиллагааг тайлагнах мэдээлэх чиглэлээр 3, нийт 4 зорилтын хүрээнд 16 арга хэмжээг төлөвлөн зохион байгуулж, төлөвлөгөөний жилийн эцсийн хэрэгжилт 96.3 хувьтай хэрэгжсэн. | |
| 11. | Арга хэмжээ:8.2 Авлигаас урьдчилан сэргийлэх чиглэлээр Авлигын эсрэг 2025 оны үйл ажиллагааны төлөвлөгөө батлуулж хэрэгжүүлнэ. | - | Төлөвлөгөөний хэрэгжилтийн хувь | Авлигын эсрэг үйл ажиллагааны төлөвлөгөөг батлуулж 90 хувьтай хэрэгжүүлсэн. | 90 | Төрийн албан хаагчдад авлига, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх мэдлэг олгох, байгууллагын ил тод байдлыг сайжруулах, Хан-Уул дүүргийн хэмжээнд төрийн үйлчилгээг иргэдэд хүнд суртал, чирэгдэлгүй хүргэх чиглэлээр 2025 онд зохион байгуулах үйл ажиллагааны төлөвлөгөөг 5 зорилтын хүрээнд 12 арга хэмжээг тусган Засаг даргын Тамгын газрын даргаар батлуулсан бөгөөд төлөвлөгөө 90 хувьтай хэрэгжсэн. | 100 |
| **Зорилт 9.** Төрийн байгууллагуудын барилга байгууламж, алба хаагчдын ажиллах орчин нөхцөлийг сайжруулах, техник, тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангах ажлыг хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ 1.2.3) | | | | | | | |
| 12. | Арга хэмжээ:9.1 Засаг даргын Тамгын газар болон 25 хороодын ашиглалтын хугацаа дууссан компьютер техник тоног төхөөрөмжид | - | Шинэчилсэн тоног төхөөрөмжийн тоо | 55 компьютер шинэчлэн, 30 компьютерт хард, рам сайжруулалт хийсэн. | 20 | Засаг даргын Тамгын газрын 2 хэлтэс, 1, 2, 3, 4, 18, 23 дугаар хорооны албан хаагчдын компьютерт SSD хард, 8gb рамыг шинэчилж, мөн Засаг даргын Тамгын газрын 5 албан | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | шинэчлэл хийх ажлыг зохион байгуулна. | | | | | хаагчдад шинээр компьютер, принтер түргэн сканер олгосон. Хурлын А болон Б заалны тоног төхөөрөмжийг шинэчилж, Иргэдэд үйлчлэх төв байрны 1-7 давхрын утасгүй интернэт буюу (Wi-Fi) төхөөрөмжийг шинээр суурилуулах ажлыг хийж гүйцэтгэсэн. Мөн оффис хэрэглээний алдаа шалгагч "Болор дуран" болон монгол хэл бичгийн хөрвүүлэгч Кимо программыг Засаг даргын Тамгын газрын 48, хорооны 25 албан хаагчдын компьютерт суурилуулж, тохируулан ажилласан. | |
| 13. | Арга хэмжээ:9.2 Төрийн байгууллагуудын шаардлагатай барилга байгууламжийг засварлан, техник тоног төхөөрөмж, тусгай хэрэгслээр хангаж, ажиллах нөхцөлийг сайжруулна. | - | Байгууллагын тоо | 8 байгууллага | 2 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар төрийн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх ажлын хүрээнд 2 байгууллагад тоног төхөөрөмж нийлүүлэгдэхээр төлөвлөгдсөн. Ажлын явцаар авч үзвэл: "Хан-Уул дүүргийн Татварын хэлтэст шаардлагатай тоног төхөөрөмж худалдан авах" ажлын гүйцэтгэгчээр "Ай ти зон" ХХК шалгаран тоног төхөөрөмж нийлүүлэгдсэн. "Хан-Уул дүүргийн Онцгой байдлын хэлтэст шаардлагатай гал унтраах, эрэн хайх тоног төхөөрөмж худалдан авах" ажлын худалдан авах ажиллагааг 3 удаа зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүй. Дахин 2025.11.17-ны өдөр тендер зарлаж, 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдөр | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нээсэн бөгөөд 1 аж ахуйн нэгж үнийн санал ирүүлж, үнэлгээ хийгдэж байна. | |
| **Зорилт 10.** Төрийн байгууллага, орон нутгийн өмчит хуулийн этгээдийн засаглалыг сайжруулах, үйлчилгээг цахимжуулахад дэмжлэг үзүүлнэ. (ЗГҮАХ 4.2.3.2, НЗДҮАХ 5.1.4, ДЗДҮАХ 1.2.4) | | | | | | | |
| 14. | Арга хэмжээ:10.1 Засгийн газрын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, үр дүнг холбогдох байгууллагад тогтмол мэдээллэнэ. | - | Холбогдох дээд, шатны байгууллагад нэгтгэж, хүргүүлсэн тайлангийн тоо Хэрэгжилтийн хувь | 5 тайлан 10 удаа, тайлагнасан. Дундаж биелэлт 97,6% | 6 тайлан 2-оос доошгүй удаа хяналт шинжилгээ хийж, тайлагнасан байна. | Монгол Улсыг 2021-2025 онд хөгжүүлэх Таван жилийн үндсэн чиглэлээс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх 1 бүлэг, 2 зорилт 4 арга хэмжээ жилийн эцсийн байдлаар 96.2%, Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 2 бүлгийн 3 арга хэмжээ 96.6%, Улсын хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 1 арга хэмжээ эхний жилийн эцсийн байдлаар 100%-ур дүнтэй хэрэгжиж, тайланг нийт 62 хуудас нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 01-ний 04/1816 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэн рүү цахимаар илгээж, тайлагнасан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 15. | Арга хэмжээ:10.2 Нийслэлийн Засаг даргын бодлогын баримт бичгийн хэрэгжилтэд хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, үр дүнг холбогдох байгууллагад тогтмол мэдээллэнэ. | - | Холбогдох дээд, шатны байгууллагад нэгтгэж, хүргүүлсэн тайлангийн тоо Хэрэгжилтийн хувь | 5 тайлан 4 удаа тайлагнасан. Дундаж биелэлт 85,3% | 8 тайлан 4-өөс доошгүй удаа хяналт шинжилгээ хийж, тайлагнасан байна. | Нийслэлийг 2021-2025 онд хөгжүүлэх 5 жилийн үндсэн чиглэлээс Хан-Уул дүүрэг хамтран хэрэгжүүлэх 3 арга хэмжээ жилийн байдлаар 100 %, хяналт-шинжилгээний 3 шалгуур үзүүлэлт 100%, Нийслэлийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө 4 бүлэг, 6 зорилго, 14 зорилт, 23 арга хэмжээ хагас жилийн байдлаар 70%, жилийн эцэст 96%, 3 бүлгийн 17 шалгуур үзүүлэлт 93,8%, Нийслэлийн хөгжлийн 2025 оны төлөвлөгөөний 5 бүлэг, 11 зорилго, 14 зорилтын 23 арга хэмжээ дунджаар 91%, 2 бүлгийн 5 шалгуур үзүүлэлт 100%-үр дүнтэй хэрэгжиж, тайланг 53 хуудас нотлох баримтын хамт 2025 оны 12 дугаар сарын 01-ний 04/1816 дугаар албан бичгээр нийслэлийн Засаг даргын Тамгын газрын холбогдох мэргэжилтэнд хугацаанд цахимаар илгээж, тайлагнасан. | 100 |
| 16. | Арга хэмжээ:10.3 Дүүргийн Засаг даргын бодлогын баримт бичгийн хяналт шинжилгээ, үнэлгээг хийж, үр дүнг холбогдох байгууллагад тогтмол мэдээллэнэ. | | Хэрэгжилтийн хувь | 2 тайлан 2 удаа тайлагнасан. Жилийн эцсийн биелэлт 91% | 2 тайлан 1-ээс доошгүй удаа хяналт шинжилгээ хийж, тайлагнасан байна. | Дүүргийн Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх төлөвлөгөөний 3 бүлэг 15 зорилго, 90 зорилтын хүрээнд 136 арга хэмжээ, үр дүнгийн хяналт-шинжилгээ, үнэлгээний 94 шалгуур үзүүлэлтийг холбогдох хэлтсүүдээс тус тус авч нэгтгэн Засгийн газар, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | нийслэлийн бодлогын баримт бичигтэй уялдуулан боловсруулж, Засаг даргын 2025 оны А/522 дугаар захирамжаар батлуулсан. Жилийн эцсийн байдлаар ..........%-үр дүнтэй хэрэгжиж, тайлан нэгтгэлийг дүүргийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлж, тайлагнахад бэлэн болсон. | |
| 17. | Арга хэмжээ: 10.4 Дүүргийн Засаг захиргааны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагаанд явцын болон гүйцэтгэлийн хяналт, шинжилгээ, үнэлгээ хийж, дүгнэлт, зөвлөмж хүргүүлнэ. | 2.0 | Харьяа байгууллагад хийсэн хяналт, шинжилгээ, үнэлгээ болон зөвлөмжийн тоо | 2 удаа Хяналт шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох байгууллагад 3 зөвлөмж хүргүүлсэн. | 2 удаа хяналт шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, тайлагнана. | Дүүргийн засаг захиргааны нэгж, харьяа байгууллагуудын үйл ажиллагааны хагас жилийн гүйцэтгэлд хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, тайланг удирдлагад танилцуулсан. Хяналт-шинжилгээ, үнэлгээний ажлын зөвлөмжийг Засаг даргын Тамгын газрын 2025 оны 04/1350 дугаар албан бичгээр дэргэдэх 30 байгууллагад хүргүүлсэн. Жилийн эцсийн гүйцэтгэлийн хяналт-шинжилгээ, үнэлгээг Архивын улсын үзлэгийн дүнд суурилан холбогдох журамд заасан шалгуурын дагуу 2025 оны 12 дугаар сарын 2 дахь 7 хоногт багтаан зохион байгуулахаар ажиллаж байна. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 18. | Арга хэмжээ:10.5 Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч дүүргийн Засаг даргатай байгуулсан Хариуцлагын гэрээний хэрэгжилтийг нэгтгэж, Хяналт-шинжилгээ, үнэлгээ хийнэ. | - | Хяналт, шинжилгээ, үнэлгээний тоо | 2 удаа Хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, тайлагнасан. | 1-ээс доошгүй удаа Хяналт, шинжилгээ үнэлгээ хийж, холбогдох албан тушаалтанд танилцуулж, тайлагнана. | Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагч дүүргийн Засаг даргатай байгуулсан 2025 оны Хариуцлагын гэрээг хэрэгжүүлэх 2 бүлэг, 10 зүйл 109 заалтыг хэрэгжүүлэх төлөвлөгөө боловсруулж, дүүргийн Засаг даргаар батлуулсан. Гэрээг хагас жилд 53,8 хувь, жилийн эцэст 93 хувь үр дүнтэй хэрэгжүүлж, нийслэлийн Засаг даргын Тамгын газарт тухай бүр гэрээнд заасан хугацаанд илгээж, тайлагнасан. | 100 |
| **Зорилт 11.** Төрийн байгууллагуудын албан хэрэг хөтлөлтийн үйл ажиллагааг цахимжуулах ажлыг үе шаттай хэрэгжүүлэхэд хамтран ажиллана. (ДЗДҮАХ 1.2.5) | | | | | | | |
| 19. | Арга хэмжээ:11.1 Дүүргийн хэмжээнд албан хэрэг хөтлөлтийн шатанд боловсруулсан баримтаар цахим хадгаламжийн нэгж үүсгэх ажлыг эхлүүлнэ. | - | Хэрэгжилтийн хувь | - | 100 | Засаг даргын Тамгын газар нь Албан хэрэг хөтлөлтийн “eDoc” программ ашиглан Захирамжлалын төслийг 2025 оны 02 дугаар сарын 04-ний өдрөөс 2025 оны 10 дугаар сарын 27-ны өдөр хүртэл нийт 100 захирамж цахимаар боловсруулах ажлыг туршилтын журмаар хэрэгжүүлсэн. Нийслэлийн архивын газраас төсөвтэй холбоотойгоор хөгжүүлэлт хийгдээгүй, Хөмрөг үүсгэгч 114 байгууллага 2024 онд үүссэн захирамжлалын баримтыг төрийн архивын нэгдсэн системд 221 хадгаламжийн нэгжийн 17084 баримтын 25815 хуудсыг цахимжуулсныг арга зүйн зөвлөгөө өгч, батлан шалгаж ажилласан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 20. | Арга хэмжээ:11.2 Дүүргийн харьяа байгууллагуудын албан бичгийн шийдвэрлэлтэд хяналт тавьж, зөрчлийн тоог багасгана. | - | Шийдвэрлэлтийн хувь, зөрчлийн тоо | Шийдвэрлэлт 98.26%, Зөрчлийн тоо 966 | 99%, зөрчлийн тоог 966-аас багасгана. | Дүүргийн Төр захиргааны нийт 117 байгууллагад арга зүйн зөвлөгөө өгч 2025 онд нийт 45083 албан бичиг ирснээс шийдвэрлэлтийн хувь 99.64, индекс 0,664 буюу шийдвэрлэлтийн дундаж хугацаа 3 хоног байна. Зөрчлийн тоо 2024 оны жилийн эцсийн байдлаар 1185 байсан бол 2025 оны жилийн эцсийн байдлаар 555 буюу 53.2%-иар буурсан үзүүлэлттэй байна. | 100 |
| **Зорилт 12.** Төрийн архивын **"Салбар архив"** байгууллах ажлыг эхлүүлж, иргэн, хуулийн этгээдэд үзүүлэх архивын үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлнэ. (НЗДҮАХ 5.2.8, ДЗДҮАХ 1.2.6) | | | | | | | |
| 21. | Арга хэмжээ:12.1 "Төрийн архивын салбар архив" байгуулах ажлыг үе шаттайгаар эхлүүлнэ. | 4.0 | Хэрэгжилтийн хувь | Дүүргийн архив 95 байгууллагын 1964-2023 оны 13853 баримтаар хөмрөг үүсгэсэн байна. | 100 | Хууль, зүй дотоод хэргийн сайдын 2021 оны А/213 дугаар тушаалаар батлагдсан Салбар архивын үйл ажиллагааны нийтлэг журамд архивын баримтын тоог нарийн гаргасан байх шаардлагатай гэж заасны дагуу Төрийн архивын хадгаламжийн сангуудад Засаг даргын Тамгын газрын даргын 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдрийн А/41 дүгээр тушаалаар баримтын тооллогын ажлыг 2025 оны 03 дугаар сарын 29-ны өдрөөс 5 дугаар сарын 10-ны өдрийн хооронд зохион байгуулсан.Тус тооллогоор дүүргийн архивд 95 байгууллагын 1964-2023 оны 13853 хадгаламжийн нэгж тоологдсон мэдээг НАГ-т хүргүүлсэн. | 100 |
| 22. | Арга хэмжээ:12.2 Төрийн архивт төлөвлөгөөт болон | - | Байгууллагын тоо | БНШАЗКомисс 5 удаа хуралдаж 32 байгууллагын 2499 | 31 | Нөхөн баяжилтын төлөвлөгөөг 2025 оны 01 дүгээр сарын 06-ны өдөр Засаг даргын Тамгын газрын | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвлөгөөт бус бүрдүүлэлт хийх хөмрөг үүсгэгч байгууллагын бүрдүүлэлтийн үйл ажиллагаанд мэргэжил арга зүйн заавар, зөвлөгөө өгч, баяжилт хийгдэнэ. | | . | баримтаар баяжилт хийгдсэн. | | даргаар батлуулсан. Төлөвлөгөөний дагуу нөхөн баяжилт хийгдэх 31 байгууллага нөхөн баяжилт хийгдэхээс 16 хорооны ИНХ тус онуудад баримт үүсээгүй тухай 2025 оны 01/11 дугаартай албан бичгээр дүүргийн ИТХ-ын Ажлын албанаас ирүүлсэн, БНШАЗК-ын 2025 оны 3 удаагийн хурлаар хэлэлцэн баталж, 15 байгууллагын 1237 баримтыг дүүргийн архивд хүлээн авч авсан. | |
| **Зорилт 13.** Дүүргийн салбар архив болон Засаг даргын Тамгын газрын архивт хадгалагдаж буй цаасан суурьт баримтыг цахим хэлбэрт шилжүүлнэ. (НЗДҮАХ 5.2.9, ДЗДҮАХ 1.2.7) | | | | | | | |
| 23. | Арга хэмжээ:13.1 Архивын баримтын нэр төрөл, хадгалах хугацааны үлгэрчилсэн жагсаалтыг боловсруулж, батлуулж, мөрдүүлнэ. | - | Нэгдсэн тоо бүртгэлд орсон баримтын тоо | Засаг даргын Тамгын газрын 2023 онд хөтлөгдөх ХХНЖ-ыг 188 хэрэгтэйгээр боловсруулж, байгууллагын БНШК-ын 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. | Тамгын газрын 2024 оны үйл ажиллагааны явцад үүсч хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг шинэчлэн боловсруулж, батлуулна. | Засаг даргын Тамгын газрын 2025 оны үйл ажиллагааны явцад үүсэж хөтлөгдөх хөтлөх хэргийн нэрийн жагсаалтыг байнгын хадгалах хэргийн 97, түр хадгалах хэргийн 110, 70 жил хадгалах хэргийн 5 нийт 212 хэрэгтэйгээр 2025 оны 03 дугаар сарын 21-ний өдөр шинэчлэн боловсруулж, байгууллагын дэргэдэх Баримт нягтлан шалгах комиссын 01 дүгээр хурлаар хэлэлцүүлэн батлуулсан. | 100 |
| 24. | Арга хэмжээ:13.2 Төрийн архивт хөмрөг үүсгэгч 13 хорооны малын А дансны 171 баримтыг үе шаттайгаар цахимжуулна. | 6.4 | 1 хорооны малын А дансны баримтыг цахимжуулна | Засаг даргын Тамгын газрын захирамжлалын **14** хадгаламжийн нэгжийн **1278** баримтын, **2718** хуудас баримтыг цахимжуулсан. | Төрийн архивт хөмрөг үүсгэгч 1 хорооны малын А дансны 1998-2017 оны 10 баримтыг цахимжуулна. | Төрийн архивт хөмрөг үүсгэгч 4 дүгээр хорооны малын А дансны 1998-2017 оны 10 хадгаламжийн нэгжийн 239 хуудас баримтыг цахимжуулсан. | 100 |
| *ДЗДҮАХ-ийн 1.2. зорилгын хүрээнд 7 зорилт 17 арга хэмжээ 98.2 хувьтай хэрэгжсэн.* | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| **ДЗДҮАХ-ийн зорилго1.3.Иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ.** | | | | | | | |
| **Зорилт 14.** Нийтийн эзэмшлийн гудамж, зам, талбайн камерын хяналтыг нэмэгдүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагын гадна орчны камерыг **"Телехяналтын камерын дэд төв"**-д холбох ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлнэ. (ЗГҮАХ 4.2.1.12, НЗДҮАХ 5.5.1, ДЗДҮАХ 1.3.1) | | | | | | | |
| 25. | Арга хэмжээ: 14.1 Нийтийн эзэмшлийн гудамж талбайн теле хяналтын камерын тоог нэмэгдүүлж, "Телехяналтын камерын дэд төв"-ийг ашиглалтад оруулна. | 834.5 (ДТХО) | Ажлын явц хувь | 20% /2024 он/ | 100 | "Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх, шуурхай мэдээлэл дамжуулах, иргэдийн аюулгүй, амар тайван амьдрах орчныг бүрдүүлэх зорилгоор 1500 хүртэл камер хянах хүчин чадалтай, сервертэй теле камерын хяналтын дэд төв Хан-Уул дүүргийн 16 дугаар хороонд 2025 оны 6 дугаар сард ашиглалтад орсон. | 100 |
| | | | Дэд төвийн ажлын явц хувь | 70% | 100 | Дэд төвийн ашиглалтын хэвийн үйл ажиллагааг хангах зорилгоор дүүргийн төсвийн хөрөнгөөр "Камерын нэгдсэн хяналтын төв рүү шилэн кабел татах, засвар тохижилт (16 дугаар хороо)"-ын ажлыг "Инносолюшн" ХХК хэрэгжүүлж ашиглалтад оруулсан. | |
| 26. | Арга хэмжээ:14.2 Нийтийн эзэмшлийн гудамж, талбайн камерын засвар, арчлалтыг сайжруулна. | 1,000.0 (ДТХО) | Засварлаж, шинэчилсэн камерын тоо, ширхэг | 157 (2024 онд 82 камер засварлаж, 75 камер шинэчилсэн) | 200 | Дүүргийн Засаг даргын 2025 оны 09 дүгээр захирамжаар нийтийн эзэмшлийн гудамж, зам талбайн камерын засвар, арчлалт хамгаалалтыг Нийтлэг үйлчилгээний алба ОНӨААТҮГ-т хариуцуулж, ажлын явц гүйцэтгэлд Хан-Уул ярмаг ОНӨААТҮГ захиалагчийн хяналт тавьж ажиллаж байна.<br>Камерын засвар, арчлалтын ажлын хүрээнд 6 цэцэрлэгийн байранд 77 камер, 1, 2, 4, 5, 7,15 дугаар хороодын байранд 36 камер буюу нийт 113 камер | 77.5 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | шинээр суурилуулж, 1, 2,3 ,4, 5, 6, 7, 8, 13, 19, 20, 24 дүгээр хороодын нийтийн эзэмшлийн зам талбайн 155 камерыг засварлаж, 15000 метр урт шилэн кабель, 16000 метр урт цахилгаан сүлжээний утсыг татан ажиллагаанд оруулсан. | |
| **Зорилт 15.** Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх сургалт, соён гэгээрүүлэх үйл ажиллагааг идэвхжүүлж, Цагдаагийн байгууллагын гэмт хэрэг, зөрчилтэй тэмцэх илрүүлэх чадавхыг сайжруулахад дэмжлэг үзүүлнэ. (ДЗДҮАХ 1.3.2) | | | | | | | |
| 27. | Арга хэмжээ:15.1 Гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт, сурталчилгаа зохион байгуулна. | 2.0 | Зохион байгуулсан сургалт болон өдөрлөг, хамрагдсан иргэн, албан хаагчдын тоо | 4 сургалт, 1 арга хэмжээ зохион байгуулж 800 иргэн, аж ахуйн нэгж байгууллагыг хамруулсан. | 3 сургалт, 1 өдөрлөг зохион байгуулж 400 иргэн, албан хаагчдыг хамруулна. | Авлигатай тэмцэх газар, дүүргийн ИТХ, Цагдаагийн газар, Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран 3 сургалт зохион байгуулж 408 иргэн, албан хаагчийг хамруулсан.<br>Үүнд:<br>1."Худалдан авах ажиллагаанд авлигын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх нь" сэдэвт сургалтыг Үнэлгээний хорооны албан хаагчдад,<br>2.Согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн холбогдох заалтын хүрээнд гэр бүлийн хүчирхийлэл үйлдэгдэх эрсдэлтэй зорилтод бүлгийн иргэдэд,<br>3.Дүүрэг дэх Хууль зүйн туслалцааны төвтэй хамтран гэмт хэргээс урьдчилан сэргийлэх чиглэлээр иргэдийн хэрэгцээнд нийцүүлсэн сургалтыг 2025 оны 11 дүгээр сарын 14-ний өдөр дүүргийн Соёлын ордонд зохион байгуулж 25 хорооны 120 иргэнд Иргэний болон Эрүүгийн хуулийн холбогдох заалтаар мэдээлэл | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүргэж, хууль зүйн туслалцаа авах талаарх сурталчилгааны брошурыг иргэдэд тарааж ажилласан. | |
| **Зорилт 16.** Батлан хамгаалах бодлого, үйл ажиллагааны хүрээнд орон нутгийн хамгаалалтын үндсэн арга хэмжээг хэрэгжүүлэх, хүүхэд залуучуудад эх оронч үзэл хүмүүжил олгох олон талт арга хэмжээг зохион байгуулж, иргэн цэргийн харилцааг бэхжүүлнэ. (ДЗДҮАХ 1.3.5) | | | | | | | |
| 28. | Арга хэмжээ:16.1 Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу 2025 оны цэргийн бүртгэлийн ажлыг зохион байгуулна. | 14.0 | Цэргийн бүртгэлийн хамралтын хувь | 93,6 | 94 | Цэргийн албаны тухай хуулийн 34 дүгээр зүйл, Батлан хамгаалахын сайдын 2017 оны "Цэргийн бүртгэл явуулах тухай" А/331 дүгээр журмыг удирдлага болгон дүүргийн Засаг даргын 2024 оны А/730 дугаар захирамжаар нийслэлийн хэмжээнд 2025 оны 01 дүгээр сарын 04-ний өдрөөс 01 дүгээр сарын 19-ний өдрүүдэд цэргийн бүртгэлийн ажлыг цахим болон цаасан суурьтай зохион байгуулахад 89,3 хувь хамрагдсан. | 89 |
| 29. | Арга хэмжээ:16.2 Батлан хамгаалах зарим чиг үүргийг 2025 онд нийслэлд төлөөлөн хэрэгжүүлэх гэрээнд туссан арга хэмжээг хэрэгжүүлнэ. | - | Гэрээний зүйл, заалтын хэрэгжилтийн хувь | 94 | 95 | Монгол Улсын Засгийн газрын Батлан Хамгаалах зарим чиг үүргийг Нийслэлд төлөөлөн 2025 онд хэрэгжүүлэх гэрээнд 6 бүлэг 38 нэр төрлийн ажил, үйлчилгээ тусгагдсанаас гэрээний хэрэгжилт 91 хувьтай байна. | 91 |
| 30. | Арга хэмжээ:16.3 Монгол цэргийн өдөр, Зэвсэгт хүчний 104 жилийн ойг угтан Зэвсэгт хүчний анги, байгууллагатай хамтран сурталчилгааны ажил болон хүүхэд залуучуудад эх оронч үзэл хүмүүжил | 12.0 | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 92 | 100 | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны А/132 дугаар захирамжаар "Иргэн-цэргийн харилцааг бэхжүүлэх өдөрлөг зохион байгуулах тухай" захирамжийг баталгаажуулж, Монгол цэргийн өдөр, Орчин цагийн Зэвсэгт хүчний үүсэн байгуулагдсаны 104 жилийн ойг тохиолдуулан төлөвлөгөөт 15 ажил төлөвлөснөөс 14 ажил биелэгдэж төлөвлөгөөний | 93 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | төлөвшүүлэх ажил зохион байгуулна. | | | | | хэрэгжилт 93,3 хувьтай биелсэн. Үйл ажиллагаанд Зэвсэгт хүчний анги, төрийн цэргийн байгууллага-6, ерөнхий боловсролын сургууль-15, хувийн хэвшлийн-1, нийт 22 байгууллагатай хамтран ажиллаж, нийт 2500 гаруй иргэдийг оролцуулж үйл ажиллагааг зохион байгуулсан. | |
| 31. | Арга хэмжээ:16.4 Монгол Улсын Үндсэн хууль, Цэргийн албаны тухай хуулийн дагуу 2025 оны ээлжит цэрэг халалт, татлагын үйл ажиллагааг зохион байгуулна. | 95.0 | Үйл ажиллагааны хэрэгжилтийн хувь | 68,2 | 100 | Нийслэлийн Засаг даргын 2025 оны А/435, А/1315, дүүргийн Засаг даргын А/205, А/458 захирамжийн дагуу 2025 оны нэг, хоёрдугаар ээлжийн цэрэг татлагыг 05, 10 дугаар саруудад зохион байгуулж Зэвсэгт хүчний Жанжин штабаас өгсөн Зэвсэгт хүчин, Хилийн ба Дотоодын цэргийг нөхөн хангах тоон даалгаврыг нэгдүгээр ээлж 100 хувь, хоёрдугаар ээлж 69 хувьтай тус тус биелүүлсэн. | 85 |
| | маягийн талаар танин мэдүүлэх, зөв дадал хэвшилд сургах, олон нийтийн оролцоог нэмэгдүүлэх мэдээлэл сурталчилгааны ажлыг зохион байгуулна. | | | | | 12-ны өдөр тус тус байгальд ээлтэй дэвшилтэт техник, технологийн хэрэглээг нэмэгдүүлэх зорилгоор "Дулаан байшин" нээлттэй өдөрлөгийг 2 удаа зохион байгуулж, гэр хорооллын 4, 5, 6, 7, 8, 9, 10, 11, 12, 13, 14, 16, 21, 22, 23 дугаар хороодын 1600 гаруй иргэдийг хамруулсан.<br>Тус өдөрлөгт орчин үеийн дэвшилтэт технологи бүхий цахилгаан халаалт, цахилгаан хуримтлуулагч, дулааны алдагдлыг бууруулах дулаалгын материал үйлдвэрлэгч 8 байгууллага оролцсон. | |
| **Зорилт 33.** Иргэдийн оролцоотойгоор гэр хорооллын нүхэн жорлонгийн тоог үе шаттайгаар багасгаж, хөрсний бохирдлыг бууруулна. (НЗДҮАХ 4.3.1, ДЗДҮАХ 2.5.2) | | | | | | | |
| 63. | Арга хэмжээ:33.1<br>Гэр хорооллын айл өрхүүдэд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийг нэвтрүүлж, хөрсний бохирдлыг бууруулахад иргэдийн оролцоог нэмэгдүүлэхэд чиглэсэн арга хэмжээг хэрэгжүүлнэ. | 200.0 (ДТХО) | Стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламж, тоо | 1828 | 1900 | "Дулаан байшин" нээлттэй өдөрлөгийн хүрээнд байгальд ээлтэй стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн дэвшилтэт технологийг гэр хорооллын 15 хорооны 680 иргэнд танилцуулж, мэдээлэл өгсөн.<br>Дүүргийн хэмжээнд стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжийн тооллогын ажлыг зохион байгуулахад 2025 оны 05 дугаар сарын 30-ны өдрийн байдлаар гэр хорооллын айл өрхийн стандартын шаардлага хангасан, хөрсөнд нэвчилтгүй 3027 ширхэг стандартын шаардлага хангасан ариун цэврийн байгууламжтай болж, 1199 ширхгээр буурсан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 64. | Арга хэмжээ:33.2 Гэр хорооллын бүсэд нүхэн жорлон, бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлнэ. | 123.8 (ДТХО) | Ариутгаж халдваргүйжүүл-сэн нүхэн жорлон, бохирын цооногийн тоо, ширхэг | 17,000 (2024 он) | 15,000 | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/299 дүгээр захирамжийн дагуу 2025 оны шинэчилсэн тооллого судалгааны дагуу гэр хорооллын айл өрхийн нийт 10,380 нүхэн жорлон, 4959 бохирын цооногийг ариутгаж халдваргүйжүүлэх ажлыг "Түвшибилэг төгөлдөр" ХХК, "Баяндэмбэрэл" ХХК тус тус гүйцэтгэсэн. | 100 |
| **Зорилт 34.** Арьс шир боловсруулах үйлдвэр, авто засвар, томоохон зах худалдааны төв зэрэг үйлдвэр, үйлчилгээ эрхлэгчдээс үүдэлтэй хүнд металлын бохирдлыг бууруулна. (НЗДҮАХ 4.3.1, 4.3.2, ДЗДҮАХ 2.5.3) | | | | | | | |
| 65. | Арга хэмжээ:34.1 Хөрсний бохирдлын судалгаа хийж, бохирдол ихтэй нийтийн эзэмшлийн гудамж, талбайг ариутгаж, халдваргүйжүүлэх арга хэмжээ авч ажиллана. | 19.0 (ДТХО) | Судалгааны тоо | - | 1 (мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлнэ) | Ариутгал халдваргүйжүүлэлтийн тусгай зөвшөөрөлтэй мэргэжлийн байгууллагатай хамтран хэрэгжүүлсэн судалгаагаар дүүргийн нийтийн эзэмшлийн гудамж талбайд хөрс, орчны бохирдол үүссэн мананцар үүсгэгч машинаар халдваргүйтгэл хийх шаардлагатай 120,000 м.кв, шүршигч багажаар ариутгах шаардлагатай бохирдол ихтэй 80,000 м.кв талбай байна. | 100 |
| | | 200.0 (ДТХО) | Ариутгаж халдваргүйжүүлсэн талбай, м.кв | 357,000 | 300,000 | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/152 дугаар захирамжийн дагуу 25 хороодын нийтийн эзэмшлийн бохирдол ихтэй, ариутгах шаардлагатай гудамж, зам талбай, хогийн цэг, хүүхдийн тоглоомын талбай, далан гуу жалганы нийт 230,000 м.кв талбайг мэргэжлийн байгууллагаар ариутгаж халдваргүйжүүлсэн. (Гүйцэтгэгч "Хансудар" ХХК) Дүүргийн Засаг даргын 2025 оны А/155 дугаар захирамжийн дагуу дүүргийн нийтийн эзэмшлийн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бохир усны шугам сүлжээ бөглөрч бохир хальсан гудамж талбайн 15 байршлын 80,500 м.кв талбайг мэргэжлийн байгууллагаар ариутгаж халдваргүйжүүлсэн. | |
| **Зорилт 35.** Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагааны улмаас бохирдсон, доройтсон, эвдэрсэн газар, газрын хэвлийг хоргүйжүүлэх, нөхөн сэргээх, хамгаалах ажлын үр дүнг дээшлүүлж, хариуцлагатай үйл ажиллагааг хэвшүүлнэ. (НЗДҮАХ 4.1.2, 4.1.7, ДЗДҮАХ 2.5.5) | | | | | | | |
| 66. | Арга хэмжээ:35.1 Түгээмэл тархацтай ашигт малтмалын олборлолт, тээвэрлэлт, нөхөн сэргээлтэд тавих хяналт шалгалтыг сайжруулж, хариуцлагыг нэмэгдүүлнэ. | 90.0 (ДТХО) | Зохион байгуулсан арга хэмжээний тоо | 3 (2024 онд хариуцлагын гэрээ байгуулах, хяналт тавих) | 2 | Нийслэлийн Засаг даргын 2022 оны А/90, 2025 оны дүүргийн Засаг даргын А/207 дугаар захирамжийн хүрээнд 25 байгууллагын 9954 тээврийн хэрэгсэлтэй "Тээвэрлэлтийн хариуцлагын гэрээ"-г байгуулсан.<br><br>Түгээмэл тархацтай ашигт малтмал олборлогч, тээвэрлүүлэгч аж ахуй нэгжүүдийн тээвэрлэлтэд хяналт тавьж ажиллахад 9954 тээврийн хэрэгслээр 238,896 тн хайрга, дайрга тээвэрлэгдсэнийг мэдээллийн санд бүртгэсэн. Хяналтаар бүтээлэггүй 115, даац хэтрүүлэн ачилт хийсэн 64, маршрутын бус замаар тээвэрлэлт хийсэн 48, устай хайрга ачин, замаар ус гоожуулсан 21 тээврийн хэрэгслийн зөрчлийг илрүүлж, арилгах арга хэмжээ авч холбогдох хууль журмын дагуу Цагдаагийн байгууллагад мэдээлэл хүргүүлсэн. | 100 |
| | | - | Нөхөн сэргээлт хийсэн байгууллагын тоо | 10 (2024 онд 10 байгууллага нөхөн | 10 | НБОГ-н даргын А/149 дүгээр тушаалаар 2025 оны нөхөн сэргээлтийг хянаж хүлээн авах ажлын хэсэг 2025 оны 11 дүгээр | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | сэргээлт хийж, хүлээлгэж өгсөн) | | сарын 15-ны өдрөөс 12 дугаар сарын 15-ны өдрийг хүртэл дүүргийн хэмжээнд нөхөн сэргээлтийг хүлээн авахаар бэлтгэл ажил хангаж байна. | |
| **Зорилт 36.** Гэр хорооллын бүсийн ус түгээх цэгийг нэмэгдүүлж, хуучин ус түгээх байрыг засварлан ухаалаг төхөөрөмж суурилуулж хүртээмжийг нэмэгдүүлнэ. (ДЗДҮАХ 2.5.6) | | | | | | | |
| 67. | Арга хэмжээ:36.1 Гэр хорооллын шаардлагатай байршлуудад ундны усны худаг гаргах, засварлах ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулна. | 109.6 (ДТХО) | Шинээр баригдсан худаг, тоо | 8 /2021-2024 он/ | 6 | Дүүргийн төсвийн 380.0 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжсэн "Шинээр гүний худаг байгуулах ажил (13, 14 дүгээр хороо)" төсөл, арга хэмжээний гүйцэтгэгчээр "Баялаг говь" ХХК ажиллаж, 13, 14 дүгээр хороонд 6 байршилд шинээр смарт ажиллагаатай гүний худаг барьж, ашиглалтад оруулсан. | 100 |
| | | | Смарт төхөөрөмж суурилуулж засварласан худаг, тоо | 6 /2021-2024 он/ | 6 | Нийслэлийн төсвийн 300.0 сая төгрөгийн хөрөнгөөр "Эйч Ти Эл" ХХК дүүргийн 10, 12, 13, 14 дүгээр хороонд нийт 11 гүний худгийн барилгыг засварлаж, ухаалаг төхөөрөмж суурилуулах ажлыг гүйцэтгэж дууссан. Байнгын ашиглалтад хүлээн авах комисс ажиллах шатанд байна. | |
| **Зорилт 37.** Хот нийтийн аж ахуйн машин, механизм, тоног төхөөрөмжийн шинэчлэлийг үргэлжлүүлж, хог хаягдлыг ангилах, цуглуулах, тээвэрлэх үйлчилгээнд технологийн шинэчлэл хийнэ. (НЗДҮАХ 4.4.2, ДЗДҮАХ 2.5.7) | | | | | | | |
| 68. | Арга хэмжээ:37.1 Хог төвлөрүүлэх цэгийн өргөж буулгадаг хогийн сав, хог буулгаж ачих крантай автомашинаар парк шинэчлэлт хийнэ. | 1,000.0 (ДТХО) | Хогийн савны тоо | - | 4 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Хог төвлөрүүлэх цэгийн өргөж буулгадаг хогийн сав, хог буулгаж ачих крантай автомашин худалдан авах" төсөл арга хэмжээний хүрээнд нийтийн эзэмшлийн гудамж, талбайд 25 ширхэг хогийн сав суурилуулахаар төлөвлөсөн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бөгөөд гүйцэтгэгч "Мөнх инспайринг" ХХК гүйцэтгэсэн.<br><br>Дээрх төсөл арга хэмжээ хэрэгжсэнээр ачигч нарын хөдөлмөрийг хөнгөвчилж, цаг хугацааг хэмнэнэ. | |
| | | | Автомашины тоо | 73 /2021-2024 он/ | 2 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй "Хог төвлөрүүлэх цэгийн өргөж буулгадаг хогийн сав, хог буулгаж ачих крантай автомашин худалдан авах" төсөл арга хэмжээний хүрээнд 2 ширхэг тусгай зориулалтын хог тээврийн авто машиныг гүйцэтгэгч "Мөнх инспайринг" ХХК нийлүүлсэн. | |
| **Зорилт 38.** Хувийн хэвшилд суурилсан хог хаягдлын менежментийн тогтолцоонд үе шаттайгаар шилжүүлнэ. (ДЗДҮАХ 2.5.9) | | | | | | | |
| 69. | Арга хэмжээ:38.1 Энгийн хог хаягдлыг цуглуулж тээвэрлэх, нийтийн эзэмшлийн гудамж талбайн цэвэрлэгээг сайжруулах арга хэмжээ авч ажиллана. | 26,903.8 (ДТХО) | Цуглуулж тээвэрлэсэн хогны жин, мян.тн | 155.5 | 120.0 мянган тн-оос багагүй | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/77 дугаар захирамжийн дагуу 1, 2, 3, 19, 20, 23 дугаар хороодын энгийн хог хаягдал тээвэрлэлтийг "Эко хотын тээвэр" ААТҮГ, 4, 5, 6, 7, 8, 24 дүгээр хороодын энгийн хог хаягдал тээвэрлэлтийг "Хан-Эко тээвэр" ААТҮГ, 9, 10, 12, 13, 14, 16 дугээр хороодын хог тээвэрлэлтийг "Тохижилт, үйлчилгээний төв" ОНӨААТҮГ, 11, 15, 17, 18, 22 дугаар хороодын энгийн хог хаягдал тээвэрлэлтийг "Хан-Уул Агро" ОНӨААТҮГ тус тус хариуцан ажиллаж байна.<br>2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар дүүргийн хэмжээнд нийт 173,577.424 тонн хог хаягдлыг 41,406 рейсээр тээвэрлэн Морингийн төвлөрсөн | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хогийн цэгт хүргэж, тээвэрлэлтэд хяналт тавин ажилласан. | |
| | | 16,221.1 (ДТХО) | Цэвэрлэх талбайн хэмжээ, сая м.кв | 3.5 | 3.8 | Хан-Уул дүүргийн хэмжээнд нийтийн эзэмшлийн гудамж, авто зам, явган замын нийт 3,826,283 м.кв талбайн цэвэрлэгээ үйлчилгээг 4 ОНӨААТҮГ, ХАА-р шалгарсан 10 хувийн хэвшлийн байгууллагаар гүйцэтгүүлж, цэвэрлэгээнээс гарсан хог хаягдал, цас мөсийг тухай бүр ачиж тээвэрлэж, цэвэр орчныг бүрдүүлж ажиллаж байна. Хөндлөнгийн хяналтыг "Хотын хөгжлийг дэмжих шинэ тосгон холбоо" ТББ-аар гүйцэтгүүлэн, сар бүрийн ажлын гүйцэтгэлээр санхүүжилтийг олгож байна. | |
| 70. | Арга хэмжээ:38.2 Хувийн хэвшлийн байгууллагуудтай хамтарч хог хаягдлыг эх үүсвэр дээр нь бууруулах, дахивар хог хаягдлыг ангилан ялгах чиглэлээр нөлөөллийн олон талт арга хэмжээг авч хэрэгжүүлнэ. | - | Зохион байгуулсан сургалт, тоо | 3 удаагийн арга хэмжээг зохион байгуулсан. | 3-аас доошгүй сургалт арга хэмжээ зохион байгуулна. | Хуванцар хог хаягдлыг дахин боловсруулах "Ти Эм Эл" ХХК дахин боловсруулах үйлдвэртэй хамтран ажиллах талаар дүүргийн 25 хороод, СӨХ-той хамтарсан уулзалтыг зохион байгуулж, 240 СӨХ хуванцар хаягдлаа нийлүүлж, дахин боловсруулж байна.<br>"Эрүүл мэнд, нийгмийн бодлогын хүрээлэн" ТББ-тай хамтран 2025 оны 10 дугаар сарын 06-ны өдөр иргэд, хороодын зохион байгуулагчид, сууц өмчлөгчдийн холбоодын төлөөлөлд зориулан хог хаягдлын менежмент болон хог хаягдлын чиглэлээр хууль эрх зүйн мэдлэг олгох, чадавхжуулах сургалт зохион байгуулж 200 гаруй хүнийг хамруулсан. | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | Мөн тус байгууллагатай хамтран дүүргийн хэмжээнд хог хаягдлын үйлчилгээний талаарх иргэдийн сэтгэл ханамжийн судалгааг хийж, үр дүн болон цаашид хог ангилан ялгах чиглэлээр авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээний талаар, хог тээврийн байгууллагууд болон хороодын албан хаагчдад танилцуулж ажилласан. | |
| *ДЗДҮАХ-ийн 2.5. зорилгын хүрээнд 7 зорилт 9 арга хэмжээ 100 хувьтай хэрэгжсэн.* | | | | | | | |
| **ДЗДҮАХ-ийн зорилго 2.6. Олон нийтийн нийгмийн эрүүл мэндийн боловсролыг дээшлүүлж, эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлнэ.** | | | | | | | |
| **Зорилт 39.** Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлыг зохион байгуулна. (НЗДҮАХ 2.1.4, ДЗДҮАХ 2.6.3) | | | | | | | |
| 71. | Арга хэмжээ:39.1 Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чанар, хүртээмжийг нэмэгдүүлж, хүүхдийн сэргийлж болох эндэгдлийг бууруулах ажлын төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангана. | 5.0 | Хэрэгжилтийн хувь | - | 80 | Эх, хүүхэд нөхөн үржихүйн эрүүл мэндийн орон тооны бус салбар зөвлөлийн төлөвлөгөөг 3 зорилт 15 арга хэмжээний хүрээнд төлөвлөн 2025 оны 05 дугаар сарын 12-ны өдөр Засаг даргын орлогчоор батлуулсан. Эх, хүүхдэд үзүүлэх эрүүл мэндийн тусламж үйлчилгээний чиглэлээр дүүргийн хэмжээнд жирэмсний хяналтад нийт 4566 жирэмсэн эмэгтэй бүртгэгдэж, 4252 буюу 93% нь жирэмсний эхний 3 сартайд хяналтад орсон. Энэ нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 1.2%-аар нэмэгдсэн үзүүлэлттэй байна. 0-1 насны нярайн эндэгдэл 27 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 7.2 промиль байна. Эрт нярайн эндэгдэл өнгөрсөн оны мөн үетэй харьцуулахад өмнөх оноос 11 тохиолдлоор буурсан. 1- | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 5 насны хүүхдийн эндэгдэл 8 тохиолдол бүртгэгдэж, 1000 амьд төрөлтөд 2.1 промиль байна. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад 2 тохиолдлоор нэмэгдсэн. Хүүхдийн эндэгдлийг магадлан хэлэлцсэн байдал: Хүүхдийн эндэгдлийн 4 удаагийн хуралд тус дүүргийн 25 хорооны 22 Өрхийн эрүүл мэндийн төвийн 146 эмч оролцож, 4 төрлийн зөвлөмж гаргасан. | |
| **Зорилт 40.** Хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, амны хөндийн өвчлөлийг эрүүлжүүлэн бууруулах **"Эрүүл шүд-Эрүүл хүүхэд"** арга хэмжээг зохион байгуулна. (ДЗДҮАХ 2.6.4) | | | | | | | |
| 72. | Арга хэмжээ:40.1 Хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгох, өвчлөлийг бууруулах "Эрүүл шүд-Эрүүл хүүхэд" арга хэмжээний нэгдсэн төлөвлөгөө батлуулж, хэрэгжилтийг хангана. | 5.0 | Хэрэгжилтийн хувь | - | 80 | Дүүргийн төвийн бүсийн 15, 32, 52, 75, 115, 130-р сургууль, алслагдсан бүсийн 10, 59, 114, 156-р сургуулийн 1-12 ангийн 11,539 хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг хийж, шүд цоорох эмгэгийн тархалт, өвчлөлттэй илэрсэн хүүхдүүдийг Эрүүл мэндийн төвийн шүдний кабинетын эмчилгээнд хамруулж, 100% эмчлэн эрүүлжүүлсэн. "Эрүүл шүд" арга хэмжээг эрчимжүүлэх, хүн амын дунд амны хөндийн эрүүл мэндийн эрсдэлт хүчин зүйлсийг бууруулах, эрүүл мэндийн боловсрол олгох, зөв дадлыг хэвшүүлэх зорилгоор "24/3 Шүдээ зөв угаа" аян, ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд "Шүд угаалтын аварга" шалгаруулах тэмцээнийг тус тус зохион байгуулж, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хүүхдүүдэд амны хөндийн эрүүл мэндийн боловсрол олгосон. | |
| **Зорилт 41.** Бүх нийтээрээ эрүүл амьдралын хэв маягийг дэмжих дасгал хөдөлгөөн, спорт, нийтийн биеийн тамираар хичээллэх, эрүүл зөв хооллох дадлыг хэвшүүлэхэд чиглэсэн арга хэмжээг тогтмол зохион байгуулна. (ДЗДҮАХ 2.6.7) | | | | | | | |
| 73. | Арга хэмжээ:41.1 Иргэдийн спортын XIII Их наадмыг зохион байгуулна. | 130.0 | Хамрагдсан иргэдийн тоо | 6500 иргэн | 6500 | Дүүргийн Засаг даргын 2025 оны А/275 дугаар захирамжаар "Бүсчилсэн хөгжлийн Иргэдийн спортын Их наадам"-ын дүүргийн аварга шалгаруулах тэмцээнийг 2025 оны 03 дугаар сарын 28-ны өдрөөс 06 дугаар сарын 15-ны өдрийг хүртэлх хугацаанд бүсчилсэн хэлбэрээр зохион байгуулсан.<br>Бүсчилсэн Иргэдийн спортын Их наадмыг спортын 7 төрлөөр 3 насны ангиллаар зохион байгуулж, нийт 1048 иргэнийг хамруулсан.<br>(Улс, нийслэлийн шигшээ тэмцээн төсвийн хязгаарлалттай холбоотойгоор зохион байгуулагдаагүй.) | 50 |
| 74. | Арга хэмжээ:41.2 "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлтийн арга хэмжээнд зохион байгуулалтыг ханган оролцоно. | 5.0 | Хамрагдсан иргэдийн тоо | 6600 иргэн | 6600 | Нийслэлийн Засаг даргын захирамжаар жил бүр уламжлал болгон зохион байгуулагддаг "Улаанбаатар марафон-2025" олон улсын гүйлтийн арга хэмжээ 2025 оны 05 дугаар сарын 24-ний өдөр Д.Сүхбаатарын талбайд зохион байгуулагдсан. Хан-Уул дүүрэг "Улаанбаатар марафон 2025" өдөрлөгийн арга хэмжээг Гадаад харилцааны яамны автомашины зогсоолд 11:00-17:00 цагийн хооронд зохион | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж, батлагдсан хөтөлбөрийн дагуу өдөрлөгт оролцогч иргэдэд зориулсан соёл урлагийн арга хэмжээ, спортын 4 төрлийн тэмцээн уралдааныг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд Хан-Уул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал, Засаг даргын Тамгын газар, Засаг даргын дэргэдэх хэлтэс, албад, 25 хороо, аж ахуйн нэгж байгууллага, сургууль, цэцэрлэг зэрэг 247 байгууллагын 2200 гаруй ажилтан, албан хаагч оролцсон. Олон улсын гүйлтийн 500м, 800м, 1500м, 5000м, 10000м, хагас болон бүтэн марафон зайд дүүргийн 6500 гаруй тамирчин оролцсон. | |
| 75. | Арга хэмжээ:41.3 "Соёл, спортыг дэмжих" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. (ДИТХ-ын 2024 оны 16 дугаар тогтоол) | 500.0 | Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тоо | 12 төсөл, арга хэмжээ | 10 | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны А/114 дүгээр захирамжийн хоёрдугаар хавсралтаар батлагдсан "Соёл, спортыг дэмжих" дэд хөтөлбөрийн 4 зорилт 18 арга хэмжээний хүрээнд 10 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн.<br>Монголын Хүүхдийн спортын VIII наадамд 348 тамирчин оролцож, спортын 31 төрөлд өрсөлдсөнөөс 36 алт, 29 мөнгө, 27 хүрэл, нийт 89 медаль хүртэж, багийн нэгдсэн дүнгээр улсын хэмжээнд Тэргүүн байранд шалгарсан.<br>Бүсчилсэн хөгжлийн Иргэдийн спортын Их наадмыг спортын 7 төрлөөр 3 насны ангиллаар бүсчилсэн хэлбэрээр зохион | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | байгуулж, нийт 1048 иргэнийг хамруулсан.<br>Монголын Бүх ард түмний Зуны спортын XVI наадамд спортын 17 төрөлд 160 тамирчин оролцож, алт 12, мөнгөн 14, хүрэл 16, нийт 42 медаль хүртэж, улсын хэмжээнд Хан-Уул дүүрэг 4-р байрт шалгарсан.<br>Тив, Дэлхийн аварга шалгаруулах жүдо болон параволейболын 5 тамирчны замын зардалд дэмжлэг үзүүлсэн.<br>Нийслэлийн ерөнхий боловсролын 59 дүгээр сургуульд "Чөлөөт бөхийн дэвжээ", дүүргийн Биеийн тамир, спортын хороонд нийтийг хамарсан спортын арга хэмжээг тогтмол зохион байгуулахад шаардлагатай хэрэгслүүдийг худалдан авах төслийг хэрэгжүүлснээр иргэд, хүүхэд, залуучуудыг биеийн тамир, спортоор хичээллэх орчин нөхцөлийг бүрдүүлсэн. | |
| **Зорилт 42.** Иргэд, аж ахуйн нэгж, байгууллагуудын оролцоотойгоор спортын төрөлжсөн уралдаан тэмцээнийг **улирал** бүр зохион байгуулж, **"Спортлог дүүрэг" /хот/** болно. (ДЗДҮАХ 2.6.8) | | | | | | | |
| 76. | Арга хэмжээ:42.1 Хан-Уул дүүргийн Засаг даргын нэрэмжит тэмцээнийг спортын 5-аас доошгүй төрлөөр зохион байгуулна. | 40.0 | Хамрагдсан байгууллага, албан хаагчдын тоо | 16 байгууллагын 600 албан хаагч (2023 он) | 15-аас доошгүй байгууллагын 400 албан хаагч | Хан-Уул дүүргийн 60 жилийн ойг угтан дүүргийн Засаг даргын нэрэмжит спортын 5 төрөлт тэмцээнийг Засаг даргын Тамгын газар, Биеийн тамир, спортын хороо, Засаг даргын Тамгын газрын спорт хамтлаг хамтран 2025 оны 11 дүгээр сарын 17-21-ний өдрүүдэд зохион байгуулсан. Тэмцээнд 35 хэлтэс, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | албадын 25 багийн давхардсан тоогоор 1350 албан хаагч оролцсон ба тэмцээнийг 3х3 сагсан бөмбөг, волейбол, корнхол, и-спорт, дартс гэсэн спортын 5 төрлөөр зохион байгуулж, шагналт байранд шалгарсан баг тамирчдыг шагнаж урамшуулсан.<br>Байгууллагын нэгдсэн дүнгээр:<br>I байр: Цагдаагийн газар<br>II байр: Татварын хэлтэс<br>III байр: Онцгой байдлын хэлтэс тус тус шалгарсан. | |
| 77. | Арга хэмжээ:42.2 Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн үйл ажиллагаанд дэмжлэг үзүүлж, хяналт тавина. | 80.0 | Гүйцэтгэлийн хувь | 100% | 100 | Дүүргийн Засаг даргын дэргэдэх өсвөрийн шигшээ багийн тамирчид дүүрэг, улс, нийслэлийн шигшээ 47 тэмцээн, олон улсын шинж чанартай 16 тэмцээнд оролцож, нийт 309 медаль хүртсэн. Монголын Хүүхдийн спортын VIII наадмын зуны спортын төрлийн Хан-Уул дүүргийн аварга шалгаруулах анхан шатны тэмцээнийг өсвөрийн тамирчдын дунд спортын 14 төрлөөр, сорил тэмцээнийг 7 төрлөөр зохион байгуулж, 299 байгууллагын 7244 тамирчныг хамруулсан. | 100 |
| *ДЗДҮАХ-ийн 2.6. зорилгын хүрээнд 4 зорилт 7 арга хэмжээ 92.8 хувьтай хэрэгжсэн.* | | | | | | | |
| **ДЗДҮАХ-ийн зорилго 2.7. Хүүхэд бүр чанартай боловсролыг тэгш, хүртээмжтэй эзэмших нөхцөлийг бүрдүүлж, суралцагчийн хөгжлийг бүх талаар дэмжинэ.** | | | | | | | |
| **Зорилт 43.** Ерөнхий боловсролын сургууль, цэцэрлэгт шаардлагатай тоног төхөөрөмж, материал хэрэгслийн дэмжлэг үзүүлж, сургалтын орчин, нөхцөлийг сайжруулна. (НЗДҮАХ 2.2.3, ДЗДҮАХ 2.7.2) | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 78. | Арга хэмжээ:43.1 Хүүхдийн сурч, хөгжих орчин нөхцөлийг сайжруулж, шаардлагатай тоног төхөөрөмж, сургалтын хэрэглэгдэхүүний дэмжлэг үзүүлнэ. | - | Дэмжлэг үзүүлсэн байгууллагын тоо | 18 байгууллага | 10 | "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийн 4.1.1 дэх зорилтын хүрээнд тус дүүргийн ерөнхий боловсролын 7 сургууль, 12 цэцэрлэгт нэн шаардлагатай сургалтын хэрэглэгдэхүүн, зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгсэл, агаар цэвэршүүлэгч олгож, хүүхдийн сурч хөгжих орчин нөхцөлийг сайжруулахад дэмжлэг үзүүлсэн. | 100 |
| 79. | Арга хэмжээ:43.2 "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. (ДИТХ-ын 2024 оны 16 дугаар тогтоол) | 500.0 | Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тоо | 42 төсөл, арга хэмжээ | 15 | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны А/114 дүгээр захирамжийн дөрөвдүгээр хавсралтаар батлагдсан "Зөв хүүхэд-Зөв ирээдүй" дэд хөтөлбөрийн 4 зорилт 32 арга хэмжээний хүрээнд 25 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн.<br>Тив, Дэлхийн аварга шалгаруулах тэмцээн уралдаанд оролцох эрх авсан 10 сурагчийн замын зардалд дэмжлэг үзүүлсэн.<br>Олон Улсын хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг тохиолдуулан зорилтот өрхийн 3250 хүүхдэд баярын бэлэг олгож, дүүргийн хэмжээнд хүүхдийн баярын нэгдсэн арга хэмжээг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 5000 гаруй хүүхэд, багачууд эцэг эх, асран хамгаалагчдын хамт оролцсон.<br>Хүүхдийн сурч хөгжих орчин нөхцөлийг сайжруулах чиглэлээр 7 сургууль, 12 цэцэрлэгт | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | сургалтын хэрэглэгдэхүүн, зөөлөн эдлэл, гал тогооны тоног төхөөрөмж, дагалдах хэрэгслийн дэмжлэг үзүүлсэн.<br><br>Хятад, Монголын хүүхэд, залуучуудын нөхөрлөлийн ой байгуулах арга хэмжээнд нийслэлийн ерөнхий боловсролын 15, 18, 52 дугаар сургуулийн 20 сурагч хамрагдсан. | |
| 80. | Арга хэмжээ:43.3 "Эрүүл мэнд, боловсролыг дэмжих" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. (ДИТХ-ын 2024 оны 16 дугаар тогтоол) | 300.0 | Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тоо | 21 төсөл, арга хэмжээ | 5 | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны А/114 дүгээр захирамжийн тавдугаар хавсралтаар батлагдсан "Эрүүл мэнд, боловсролыг дэмжих" дэд хөтөлбөрийн 5 зорилт, 24 арга хэмжээний хүрээнд 4 төсөл, арга хэмжээг зохион байгуулсан.<br>Дүүргийн хэмжээнд "Хиймэл оюун ухаанд суурилсан умайн хүзүүний оношилгоо" төслийг хэрэгжүүлснээр 12,650 эмэгтэй умайн хүзүүний хорт хавдрыг эрт илрүүлэх хиймэл оюун ухаанд суурилсан дуран, умай хүзүүний эсийн шинжилгээнд хамрагдсан.<br>"Эрүүл аюулгүй сургууль" төслийн хүрээнд төвийн бүсийн 7, алсын бүсийн 4 сургуулийн 1-12 дугаар ангийн нийт сурагчдыг урьдчилан сэргийлэх 10 төрлийн үзлэг оношилгоонд хамруулах ажлыг гүйцэтгэх бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар 5726 сурагчийг хамруулаад байна.<br>"Өсвөр үе-Өсөлт хөгжлийн үнэлгээ" төслийн хүрээнд төвийн | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | бүсийн 7 сургуулийн 5-10 дугаар ангийн сурагчдыг өсөлт хөгжлийн үнэлгээ, эрдсийн шинжилгээ, сэтгэлзүйн оношилгоонд хамруулах ба 2025 оны 11 дүгээр сарын 25-ны байдлаар 580 сурагчийг хамруулсан байна. | |
| **Зорилт 44.** Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдын дунд монгол бичиг, гадаад хэл болон байгалийн ухааны уралдаан тэмцээнүүдийг жил бүр зохион байгуулж, сургалтын чанарыг ахиулахад дэмжлэг үзүүлнэ. (ДЗДҮАХ 2.7.3) | | | | | | | |
| 81. | Арга хэмжээ:44.1 Дүүргийн Засаг даргын нэрэмжит олимпиадыг зохион байгуулж, сурагчдын оролцоог нэмэгдүүлнэ. | 30.0 | Зохион байгуулсан олимпиадын тоо | 3 төрлийн олимпиад | 5 | 2025-2026 оны хичээлийн жилд улсын төрөлжсөн олимпиадыг дүүргийн хэмжээнд 12 судлагдахуунаар зохион байгуулсан. Төрөлжсөн олимпиадад тус дүүргийн 3854 сургагч, 361 багш хамрагдсан. (Дүүргийн Засаг даргын нэрэмжит олимпиад төсвийн хязгаарлалттай холбоотойгоор зохион байгуулагдаагүй.) | 30 |
| **Зорилт 45.** Ерөнхий боловсролын сургуулиудад математик, физик, хими, гадаад хэлний төрөлжсөн кабинет байгуулах ажлыг шат дараатайгаар хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ 2.7.4) | | | | | | | |
| 82. | Арга хэмжээ:45.1 Ерөнхий боловсролын 7, 15, 26 , 32, 118, 130 дугаар сургуульд шинээр лаборатори анги байгуулахад шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангах ажлыг зохион байгуулна. | 440.0 (ДТХО) | Тоног төхөөрөмжөөр хангах ажлын явц, хувь | - | 100 | Боловсролын чанар, хүртээмжийг сайжруулах ажлын хүрээнд дүүргийн төсвийн 440.0 сая төгрөгийн хөрөнгөөр 7, 32 дугаар сургуульд байгалийн ухааны лаборатори, 118, 130 дугаар сургуулийн хими, гадаад хэл, монгол хэлний кабинет, 26 дугаар сургуульд мэдээлэл технологийн лаборатори анги байгуулах төсөл арга хэмжээг хэрэгжүүлж, шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангаж, тохижуулсан.<br><br>Ерөнхий боловсролын 15 дугаар сургуульд мэдээлэл технологийн лаборатори анги байгуулах ажлын | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | худалдан авах ажиллагааг 3 удаа зохион байгуулахад гүйцэтгэгч шалгараагүй тул дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2025 оны 08 дугаар сарын 29-ний өдрийн 09 дүгээр тогтоолоор хассан. | |
| *ДЗДҮАХ-ийн 2.8. зорилгын хүрээнд 3 зорилт 5 арга хэмжээ 84 хувьтай хэрэгжсэн.* | | | | | | | |
| **ДЗДҮАХ-ийн зорилго 2.9. Хүүхэд, гэр бүл, залуучуудын хөгжлийг дэмжиж, соёл болон хамгааллын олон талт арга хэмжээг хэрэгжүүлнэ.** | | | | | | | |
| **Зорилт 46.** Өсвөр үе, залуучуудыг сөрөг зан үйл, хорт зуршил, цахим дээрэлхэлтээс ангид байх, хувь хүний хөгжлийг дэмжих сургалт, нөлөөллийн ажлыг зохион байгуулна. (ДЗДҮАХ 2.9.3) | | | | | | | |
| 83. | Арга хэмжээ:46.1 Өсвөр үе, залуучуудын дунд хорт зуршлаас татгалзах уриалга бүхий видео контентын уралдаан зохион байгуулна. | 5.0 | Зохион байгуулсан уралдаан, хамрагдсан сурагчдын тоо | 1 удаагийн уралдаан, 120 сурагч | 1 удаагийн уралдаан, 100 | Өсвөр үе, хүүхэд, залуучуудыг сөрөг зан үйл, хорт зуршлаас татгалзах, урьдчилан сэргийлэх чиглэлээр дүүргийн Эрүүл мэндийн төвтэй хамтран нийслэлийн ерөнхий боловсролын 10, 15, 26, 41, 59, 60, 75, 114, 115, 118, 130, Монгол-Оюу билэг, Цэлмэг дижитал сургууль зэрэг нийт 15 сургуульд "Тамхины хор уршиг ба дам тамхидалтын талаарх ойлголт", "Архины хор уршиг", "Сэтгэл зүйн онцлог" сэдвээр сургалт, нөлөөллийн ажлыг 2025 оны II улиралд зохион байгуулсан. Тус нөлөөллийн үйл ажиллагаанд нийт 11578 сурагчид хамрагдсан байна. | 30 |
| 84. | Арга хэмжээ:46.2 "Ахмадаа дээдэлье" дэд хөтөлбөрийг хэрэгжүүлнэ. (ДИТХ-ын 2024 оны 16 дугаар тогтоол) | 500.0 | Хэрэгжсэн төсөл, арга хэмжээний тоо | 5 төсөл, арга хэмжээ | 5 | Хан-Уул дүүргийн Засаг даргын 2025 оны А/114 дүгээр захирамжийн гуравдугаар хавсралтаар батлагдсан "Ахмадаа дээдэлье" дэд хөтөлбөрийн 3 зорилт, 12 арга | 70 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээний хүрээнд 3 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн. Сар шинийн баярыг тохиолдуулан ахмад настнуудад хүндэтгэл үзүүлэх "Цагаан сар" төслийг хэрэгжүүлж, нийт 5000 ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн. Ахмад настнуудын дунд зохион байгуулсан цэнгээнт бүжгийн “Хаврын аяз” төслийн хүрээнд 100 ахмад хамрагдсан ба ахмад настнуудын эрүүл мэндийг дэмжиж, чөлөөт цагийг зөв боловсон өнгөрүүлэхэд дэмжлэг үзүүлсэн. “Ахмадын баяр-2025” төслийг хэрэгжүүлж, тус дүүргийн 25 хорооны 4147 ахмад настанд хүндэтгэл үзүүлсэн. | |
| 85. | Арга хэмжээ:46.3 Өсвөр үе, залуучуудад согтууруулах ундаа, мансууруулах төрлийн бодис хэрэглэх хорт зуршлаас урьдчилан сэргийлэх болон цахим дээрэлхэлтээс ангид байх, хувь хүний хөгжлийг дэмжих эрх зүйн сургалт, зохион байгуулна. | 1.0 | Зохион байгуулсан сургалт болон өдөрлөг, хамрагдсан сурагчдын тоо | 4 сургалт, 1 арга хэмжээ зохион байгуулж 2000 иргэн, сурагчийг хамруулсан. | 5 сургалт, 1 арга хэмжээ зохион байгуулж 1200 иргэн, сурагчийг хамруулсан. | Дүүргийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх ажлыг зохицуулах салбар зөвлөл, Цагдаагийн газар, Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллын хэлтэс, Цагдаагийн газартай хамтран эрх зүйн 4 удаагийн сургалтыг зохион байгуулж 1510 сурагчдыг хамруулж, ажилласан. Нийслэлийн Цагдаагийн газраас зохион байгуулсан 1 хэлэлцүүлэгт оролцож, цагдаагийн байгууллагаас зарлаж байгаа 1 сарын мэдээлэл, нөлөөллийн аянд нэгдэж, рийл бичлэгийг дүүргийн цахим хуудаснуудад байршуулан сурталчилж байна. Үүнд: | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 1.“Цахим гэмт хэрэг, хорт зуршлуудын хор уршиг, үе тэнгийн дээрэлхэлт, гэмт хэргээс өөрийгөө болон бусдыг хэрхэн хамгаалах вэ?”<br>2.“Хүүхэд гэмт хэрэг, зөрчил, хүчирхийлэл, үе тэнгийн дээрэлхэлтэд өртөхөөс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээг авах” сэдэвт сургалтыг тус тус зохион байгуулж ажилласан.<br>3.Нийслэлийн Цагдаагийн газраас зохион байгуулсан "Хүүхдийг гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэхэд төрийн болон төрийн бус байгууллагуудын үүрэг оролцоо" сэдэвт хэлэлцүүлэгт Засаг даргын Тамгын газрын дарга оролцож, тулгамдаж байгаа асуудал, цаашид хийгдэх ажлын талаарх мэдээлэл, санал солилцсон.<br>4.Дүүргийн ИТХ, Цагдаагийн газартай хамтран “Цахим гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн хүмүүжил, ажил мэргэжлийн сонголт хийх” сэдэвт сургалтыг Соёлын ордонд зохион байгуулж, Ерөнхий боловсролын 7 сургуулийн ахлах ангийн 1360 сурагчдад мэдээлэл, нөлөөллийн ажлыг зохион байгуулсан.<br>5.**“365 АНХААРЧ ХАЙРЛАЯ”** уриатай мэдээлэл, нөлөөллийн ажлыг цагдаагийн байгууллагаас 1 сарын хугацаанд зохион байгуулж, уг аянд дүүргийн Засаг | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дарга нэгдсэнийг рийл бичлэг болгож дүүргийн болон Цагдаагийн газар, 25 хорооны цахим хуудсуудад байршуулан сурталчилж байна. | |
| **Зорилт 47**. Ашиглалтын шаардлага хангахгүй дүүргийн Соёлын ордны барилгыг дахин төлөвлөж соёл, урлагийн арга хэмжээг нэгдсэн байдлаар зохион байгуулах боломжтой барилга, байгууламжийг шинээр барина. (ДЗДҮАХ 2.9.6) | | | | | | | |
| 86. | Арга хэмжээ: 47.1 Ашиглалтын шаардлага хангахгүй дүүргийн Соёлын ордны барилгыг буулгаж шинээр барих ажлын зураг төсвийг боловсруулж магадлал хийлгүүлнэ. | - | Зураг төсөв магадлал хийгдсэн эсэх | - | Зураг төслийг магадлалаар баталгаажуулсан байна. | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар ашиглалтын шаардлага хангахгүй Соёлын ордны барилгыг буулгаж, шинээр барих ажлын зураг төсвийн гүйцэтгэгчээр "Ньюкон" ХХК ажиллаж байна.<br>Соёлын ордны барилгын ажлын загвар зураг батлагдаж, холбогдох байгууллагуудаас техникийн нөхцөл хүссэн, ажлын зураг төсөл боловсруулах шатанд 60 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна. | 60 |
| *ДЗДҮАХ-ийн 2.9. зорилгын хүрээнд 2 зорилт 4 арга хэмжээ 65 хувьтай хэрэгжсэн.* | | | | | | | |
| **ДЗДҮАХ-ийн зорилго 3.1 Иргэдийн амьдрах орчны хүртээмжийг сайжруулна.** | | | | | | | |
| **Зорилт 48.** Иргэдийн амьдрах орчны хүртээмжийг хангахад чиглэсэн хотын стандартын баримт бичгийг сурталчлан таниулах, нутаг дэвсгэрийн хэмжээнд мөрдүүлэх арга хэмжээг тогтмол хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ 3.1.1) | | | | | | | |
| 87. | Арга хэмжээ:48.1 Хотын стандартыг мөрдүүлэх, хэрэгжүүлэх, аж ахуйн нэгж, байгууллагуудад сурталчлан таниулах, сургалт арга зүйгээр хангахад чиглэсэн арга хэмжээ авч ажиллана. | - | Зохион байгуулсан арга хэмжээ, тоо | 6 (хотын стандартыг хангах чиглэлээр 2024 онд 6 төрлийн арга хэмжээг хэрэгжүүлсэн) | 2 | Стандарт, норм, дүрэм мөрдүүлэх хэрэгжилтийг хангах ажлын хүрээнд "Хотын стандарт түүний хэрэгжилт, III ээлжийн 7 бүлгийн 16 хотын стандартын танилцуулга" сургалтыг Хот байгуулалт, хотын стандартын газартай хамтран 2025 оны 05 дугаар сарын 23-ны өдөр, 10 дугаар сарын 30-ны өдөр тус тус 2 удаа зохион байгуулсан. Тус сургалтад дүүргийн Засаг даргын Тамгын газар, Засаг даргын | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | дэргэдэх хэлтэс албадын төлөөлөл, орон нутгийн өмчит байгууллагууд, хороодын Засаг дарга, зохион байгуулагч, хэсгийн ахлагч зэрэг нийт 127 ажилтан албан хаагч хамрагдсан. | |
| **Зорилт 49.** Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд инженерийн болон нийгмийн дэд бүтцээр бүрэн хангагдсан орон сууцны хороолол барих төлөвлөлтийг талуудтай хамтран хэрэгжүүлнэ. (НЗДҮАХ 1.2.12, ДЗДҮАХ 3.1.2) | | | | | | | |
| 88. | Арга хэмжээ: 49.1<br>Гэр хорооллын дахин төлөвлөлтийн ажлын явцад холбогдох байгууллага, иргэдтэй хамтран ажиллах, хэрэгжилт үр дүнг тооцох, удирдлагыг мэдээллээр хангана. | - | Дахин төлөвлөлт үр дүнтэй хэрэгжсэн эсэх | 4 блок 480 айлын орон сууц ашиглалтад оруулсан. | Дахин төлөвлөлтийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд мэдээллээр хангасан байна. | Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах ажлын хүрээнд 10 хэсэгчилсэн талбайд хэрэгжих дахин төлөвлөлтийн төслөөс 2 хэсэгчилсэн талбайн гүйцэтгэгч шалгараагүй байна.<br><br>2025 онд 8 дугаар хорооны Б хэсэгчилсэн талбайн төслийг гүйцэтгэх "Нийслэлийн орон сууцны корпорац" ХХК, 8 дугаар хорооны А хэсэгчилсэн талбайн төслийг хэрэгжүүлэх "Монголиан инвесмент" ХХК-ийн төсөл хэрэгжүүлэх эрх батламжлагдсан байна.<br><br>Дүүргийн 4, 5, 6, 7, 8 дугаар хорооны нутаг дэвсгэрт үргэлжлэн хэрэгжиж буй 199.85 га талбай бүхий 6 хэсэгчилсэн талбайн нөлөөлөлд өртсөн 3411 нэгж талбарыг чөлөөлөхөөс 457 нэгж талбарыг чөлөөлж, 278 нэгж талбарын эзэмшигчтэй гурван талт гэрээ байгуулсан байна.<br><br>Гэр хорооллын газрыг дахин төлөвлөн барилгажуулах төслийн хүрээнд Хан-Уул дүүргийн хэмжээнд 273 барилга, 19910 өрх, | 100 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | 7600 суудалтай сургууль, 3350 ортой цэцэрлэг, 2 эмнэлэг байгуулахаар төлөвлөгдсөнөөс 2025 оны 11 дүгээр сарын байдлаар өссөн дүнгээр 5 блок 600 айлын орон сууц ашиглалтад орж, өрхүүдийн орон сууцны нөхцөл сайжирсан байна. Мөн 2025 онд МД ТОП ХХК 8 дугаар хорооны "А" хэсэгчилсэн талбайн гэр хорооллын дахин төлөвлөлт хэрэгжүүлэх төслийн гүйцэтгэгчээр шалгаран батламжлаад байна. | |
| **Зорилт 50.** Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны барилгыг буулган шинээр барилгажуулах ажлыг үргэлжлүүлж, айл, өрхийн орон сууцыг стандартын шаардлагад нийцүүлэх ажлыг хамтран хэрэгжүүлнэ. (ДЗДҮАХ 3.1.3) | | | | | | | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| 89. | Арга хэмжээ: 50.1 Ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай орон сууцны дахин төлөвлөлтийн ажлын хэрэгжилт үр дүнг тооцох, удирдлагыг мэдээллээр хангана. | - | Дахин төлөвлөлт үр дүнтэй хэрэгжсэн эсэх | АШХНЗОС-ы 35 барилгаас 12 барилга дахин төлөвлөгдөж, ашиглалтад орсон. (2339 өрх) | Дахин төлөвлөлтийн үйл ажиллагааг эрчимжүүлэхэд мэдээллээр хангасан байна. | Дүүргийн хэмжээнд 1, 2, 3, 4, 5, 6, 10, 11, 12, 13 дугаар хороодод ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай нийт 1655 айлын 59 орон сууцны барилгаас 36 барилгын төсөл хэрэгжүүлэгч шалгарсан.<br><br>Дүүргийн 2, 3, 10 дугаар хорооны нийт 2479 айлын 14 орон сууц ашиглалтад оруулахаар төлөвлөгдсөнөөс 10 дугаар хорооны 140 айлын 1 блок улсын комисст хүлээлгэн өгөхөөр ажиллаж бөгөөд дахин төлөвлөлтийн төсөлд хамрагдсан 327 өрхийг шинэ орон сууцаар хангасан.<br><br>Үлдсэн ашиглалтын шаардлага хангахгүй нийтийн зориулалттай 23 орон сууцны барилгын төсөл 2025 онд сонгон шалгаруулах урилга зарлагдах 13, батламж гардуулсан боловч татгалзсан 1 (1-р хороо 1-р байр), дахин төлөвлөлтийн журмын шаардлага хангаагүй 9 барилгад дүгнэлт гаргуулахаар ажиллаж байна. | 100 |
| *ДЗДҮАХ-ийн 3.1. зорилгын хүрээнд 3 зорилт 3 арга хэмжээ 100 хувьтай хэрэгжсэн.* | | | | | | | |
| **ДЗДҮАХ-ийн зорилго 3.2. Дэд бүтцийн хангамжийн шугам сүлжээний хүчин чадлыг нэмэгдүүлэх замаар хүртээмжтэй байдлыг хангана.** | | | | | | | |
| **Зорилт 51.** Цахилгаан хангамжийн хуваарилах байгууламж, дэд өртөө барьж, гэрэл цахилгаангүй болон хүчдэлийн уналттай өрхийг цахилгаан эрчим хүчээр хангах ажлыг үе шаттай хэрэгжүүлнэ. (НЗДҮАХ 1.3.3, ДЗДҮАХ 3.2.1) | | | | | | | |
| 90. | Арга хэмжээ: 51.1 Дүүргийн 10, 12, 13, 14 дүгээр хороодын хүчдэлийн уналттай | 1,561.3 (ДТХО) | Цахилгаан эрчим хүчээр хангагдсан өрх, тоо | 715 /2021-2024 он/ | 300 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар 10, 12, 13, 14 дүгээр хорооны 704 өрхийн цахилгаан | 95 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | болон гэрэл цахилгаангүй өрхийг цахилгаан шугам, сүлжээнд холбоно. | | | | | хүчдэлийг сайжруулах 3 төсөл, арга хэмжээ хэрэгжиж байна. Ажлын явц, гүйцэтгэлээр авч үзвэл: 1. Дүүргийн төсвийн 811.3 сая төгрөгийн хөрөнгөөр "Өндрийн удам" ХХК 14 дүгээр хорооны 174 өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах ажлын гүйцэтгэж, ашиглалтад оруулсан. 2. Дүүргийн төсвийн 750.0 сая төгрөгийн хөрөнгөөр "Бүрэн Холбоо констракшн" ХХК 10, 12, 14 дүгээр хорооны 150 өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах ажлыг гүйцэтгэж дууссан. Байнгын ашиглалтад авах улсын комисс ажиллах шатанд хэрэгжиж байна. Дүүргийн төсвийн 1.14 тэрбум төгрөгийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж буй 13 дугаар хорооны 380 орчим өрхийн цахилгааны хүчдэл сайжруулах ажлын гүйцэтгэгчээр "Эйч Ар Ви констракшн" ХХК шалгарч гэрээ байгуулсан бөгөөд 2025 оны 11 дүгээр сарын 24-ний өдрийн байдлаар шон суурилуулах ажил дууссан, кабель шугам татах, тоноглол суурилуулах ажил хийгдэж байна. Ажлын явц 85%. | |
| **Зорилт 52.** Үер, усны эрсдэлтэй бүсэд далан суваг барих, зам талбайн ус зайлуулах сүлжээгүй хороолол, хотхонуудыг ус зайлуулах шугам сүлжээнд холбох арга хэмжээг зохион байгуулна. (НЗДҮАХ 1.3.12, ДЗДҮАХ 3.2.2) | | | | | | | |
| 91. | Арга хэмжээ:52.1 Дүүргийн 3, 13, 14, 15, 24 дүгээр хороодын шаардлагатай байршилд ус | 6,174.2 (НТХО) 3,059.3 (ДТХО) | Ашиглалтад орсон ус зайлуулах сувгийн урт, км | 4.8 км /2021-2024 он/ | 18 км | Нийслэлийн төсвийн хөрөнгө хөрөнгө оруулалтаар Геодези, усны барилга байгууламжийн газар ОНӨААТҮГ Хан-Уул дүүргийн 1, 3, 15, 20 дугаар | 90 |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | зайлуулах суваг, далан барьж байгуулна. | | | | | хорооны 3 байршилд 9.0 км борооны ус зайлуулах шугамын өргөтгөл, шинэчлэл, 8, 21 дүгээр хорооны Жаргалантын амны үерийн байгууламжийн үргэлжлэл 438 метр далангийн ажлыг хэрэгжүүлсэн.<br><br>Нийслэлийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжихээр төлөвлөгдсөн "Арцат, Нүхт, Морь барьдгийн ам, уяачдын хотхоны үерийн хамгаалалтын барилга байгууламж (ХУД, 4,5,6,7,8 дугаар хороо)" төсөл, арга хэмжээний хүрээнд 5 км урт үерийн далан, сувгийн ажлын гүйцэтгэгчээр "Монгол менежмент төв" ХХК шалгарсан боловч нийслэлийн төсвийн тодотголоор хасагдсан.<br><br>Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжих 2 төсөл, арга хэмжээний хүрээнд нийт 2.8 км урт үерийн ус зайлуулах далан, шугамын ажлыг гүйцэтгэхээр төлөвлөснөөс 24 дүгээр хороонд хэрэгжихээр төлөвлөгдсөн үерийн далангийн ажил хувийн хэвшлийн эзэмшлийн газар, барилгажилтын талбай давхардаж, дүүргийн төсвийн тодотголоор хасагдсан.<br><br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр "Би Ди инженеринг" ХХК-ийн гүйцэтгэж буй 13, 14 дүгээр хорооны 2.5 км үерийн далангийн | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | засвар, шинэчлэлтийн ажил байнгын ашиглалтад оруулах улсын комисс ажиллуулах шатанд хэрэгжиж байна. | |
| **Зорилт 53.** Нийтийн зориулалттай орон сууцны цахилгаан шат, дээвэр, фасад, инженерийн шугам сүлжээг өргөтгөн шинэчлэх ажлыг мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг үндэслэн хэрэгжүүлж, иргэдийн ая тухтай орчинд амьдрах нөхцөлийг бүрдүүлнэ. (НЗДҮАХ 1.2.20, ДЗДҮАХ 3.2.3) | | | | | | | |
| 92. | Арга хэмжээ:53.1 Нийтийн зориулалттай хуучин орон сууцны дээвэр, фасадыг шинэчлэн засварлах ажлыг үргэлжлүүлэн ашиглалтад оруулна. | - | Фасад засвар ажлын явц, хувь | 40% /2024 он/ | 100 | Дүүргийн төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж байгаа “Нийтийн зориулалттай орон сууцны фасад засварын ажил” төсөл, арга хэмжээний хүрээнд 2 дугаар хорооны 20 дугаар байрны фасад засварын ажлыг “Эм ти Эм Жи” ХХК гүйцэтгэж, хүлээлгэн өгсөн.<br><br>Нийслэлийн төсвийн 945.9 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 1 дүгээр хорооны 37 дугаар байр, 2 дугаар хороо 3 дугаар байр, 3 дугаар хороо 20 дугаар байрны фасад засварын ажлын гүйцэтгэгчээр “Эс Эй Би Эм” ХХК шалгарч, гэрээ байгуулагдсан бөгөөд засварын ажил 2026 онд хэрэгжинэ. | 100 |
| | | | Дээвэр засвар ажлын явц, хувь | 30% /2024 он/ | 100 | Нийслэлийн төсвийн 5,310.1 сая төгрөгийн хөрөнгө оруулалтаар 3 багц төсөл арга хэмжээ хэрэгжиж байна. Ажлын явцаар авч үзвэл:<br><br>Багц-1. Гүйцэтгэгчээр “Буяннэмэх интер” ХХК шалгарч, дүүргийн 1 дүгээр хорооны 1, 2, 7 дугаар байр, 2 дугаар хорооны 12а, 12б, 12в, 23 дугаар байр, 3 дугаар хорооны Энхийг сахиулах 50 айл, 15-р | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хорооны 25, 26, 27, 28 дугаар байрнуудын дээврийг засварласан.<br><br>Багц-2. Гүйцэтгэгчээр "Таван од констракшн" ХХК шалгарч, 2025 оны 10 дугаар сарын 30-ны өдөр гэрээ байгуулсан. Тус ажлын хүрээнд 10 дугаар хорооны 2, 7, 58, 60/2, 64 байр, 15 дугаар хорооны 51, 51а, 51б байр, 19 дүгээр хороо 81, 84, 92, 81а, 81б, 81в байрны дээвэр засварын ажлыг 2026 онд хэрэгжүүлнэ.<br><br>Багц-3. Гүйцэтгэгчээр "Интел хайтек" ХХК шалгарч, дүүргийн 1 дүгээр хорооны 6, 48 дугаар байр, 2 дугаар хорооны 33 дугаар байр, 3 дугаар хорооны 17, 19, 50, 115 дугаар байр, 10 дугаар хорооны 35а, 65 дугаар байр, 19 дүгээр хорооны 25/1, 48а, 48б, 62, 91 дүгээр байр, 20 дугаар хорооны 32, 57, 106а, 106б, 106в байрны дээвэр засварын ажил 70 хувийн гүйцэтгэлтэй хэрэгжиж байна.<br><br>Дүүргийн төсвийн хөрөнгөөр он дамжин хэрэгжсэн 2 төсөл арга хэмжээний хүрээнд 3 дугаар хорооны 20 дугаар байр 15 дугаар хорооны 17, 21, 25, 2, 49а, 49б байр, 19 дүгээр хорооны 15.1, 15.2, 59, 87 дугаар байр, 24 дүгээр хорооны 107 дугаар байрны дээврийг засварласан.<br><br>Нийт дүүргийн хэмжээнд он дамжин хэрэгжиж байгаа төсөл арга | |

| 1 | 2 | 3 | 4 | 5 | 6 | 7 | 8 |
|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | хэмжээний хүрээнд 12, шинээр хэрэгжих 43 нийтийн зориулалттай орон сууцны дээвэр засварын ажлыг 2025 онд гүйцэтгэхээр төлөвлөснөөс 37 байрны дээвэр засварын ажил хэрэгжиж дууссан, 18 байрны дээвэр засварын ажил он дамжин хэрэгжүүлнэ. | |
